



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ,
ЗӨХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

НЭГ ХОТ СТАНДАРТ

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

Улаанбаатар хот
2020 он

ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

БАТАЛСАН АЛБАН ТУШААЛТНЫ
ГАРЫН ҮСГИЙН ТАЙЛАЛ

ТАНИЛЦСАН:
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА /О.ОДЖАРГАЛ/

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА /Э.ДАВААХАТАН/

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: /С.БОЛДОО/

ГАРЧИГ

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан заалтын хэрэгжилт
- 1.2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан заалтын хэрэгжилт.

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 2.1. Хууль, тогтоол шийдвэрийн хэрэгжилт.
 - 2.1.1 Хуулийн хэрэгжилт.
 - 2.1.2 Монгол Улсын Засгийн газрын тогтоол.
 - 2.1.3 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол.
- 2.2 Нийслэлийн засаг даргын захирамж, шийдвэрийн хэрэгжилт.
 - 2.1.2 Нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар.
 - 2.1.3 Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар.
 - 2.1.4 Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгавар.
- 2.2 Зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил.
 - 2.2.1 Зорилтот жилийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах.
 - 2.2.2 Төлөвлөгөөний хэрэгжилт.
 - 2.2.3 Төлөвлөгөөний биелэлт, дүгнэлт гаргах.

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

- 3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт.
- 3.2. Хүний нөөцийн бодлого хэрэгжилт.
- 3.3. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт.
- 3.4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл.
- 3.5. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлсэн үнэлгээний хэрэгжилт.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- 4.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган ажилласан талаарх мэдээлэл.
- 4.2. Байгууллагын үйл ажиллагааг сурталчилах.
- 4.3. Байгууллагын ил тод байдлын хэрэгжилт.

БУСАД МЭДЭЭЛЭЛ

- 5.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан мэдээлэл.
 - 5.2. Хэлтсүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл.
 - 5.3. Иргэд аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны хэрэгжилт.
 - 5.4. Цаг үеийн асуудлаар зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилт
- Дүгнэлт цаашид анхаарах асуудал**

ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар нь Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг хангахад чиглэсэн Хотын стандарт, норм, дүрмийг боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зохион байгуулах чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/1000 дугаар захирамжаар байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн баталснаар тус газар нь 6 хэлтэс, 60 ажилтан албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Газрын бүтэц чиг үүрэгт нэмэлтээр “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах” гэсэн заалт орсонтой холбогдуулан Хот байгуулалт хөгжлийн газарт тус чиглэлээр ажиллаж байсан 9 албан хаагчийг шилжүүлэн томилж шинэ чиг үүргээ мэргэжлийн түвшинд зохион байгуулан ажиллаж эхэлсэн нь тус газрын сүүлийн хагас жилийн үйл ажиллагааны онцлог байлаа.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН.

1.1 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудын хэрэгжилт:

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд шууд хариуцан хэрэгжүүлэх 2, хамтран хэрэгжүүлэх 5 ажил нийт 7 ажил тусгагдсан бөгөөд 2020 оны байдлаар үндсэн чиглэлийн биелэлтийг 4 удаа нэгтгэн гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст тухай бүр хүргүүлэн ажиллав.

1.1.1 Хотын стандарт, дэд бүтцийн норм нормативыг судлах, олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах /НЭЗНХҮЧ-ийн 2.2-д тусгагдсан арга хэмжээ/ ажлын хүрээнд:

Хот төлөвлөлт, хот байгуулалт, барилга дэд бүтэц, хот нийтийн аж ахуйн салбарт хамаарах иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлд шууд нөлөөлж байгаа асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр нийт 22 бүлэг сэдвийн хүрээнд 97 төрлийн “Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичиг” боловсруулахаар төлөвлөснөөс 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 51 төрлийн баримт бичгийг боловсруулж дууссан, 40 төрлийн баримт бичгийн төслийг хянаж байгаа бөгөөд энэ ажлын гүйцэтгэл **91,5%**-тай байна.

Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичгийг боловсруулах
ажлын явц

Д/д	Стандартын баримт бичгийн ажлын явц	Тоо	Тайлбар
1.	Нийслэлийн хэмжээнд мөрдүүлж эхэлсэн.	14	НЗД-ын 2020 оны “Хотын стандартын баримт бичгийг мөрдүүлэх тухай” А/456 дугаар захирамжаар батлагдсан. Гүйцэтгэл -100%
2.	Баримт бичгийг боловсруулж дууссан.	37	Холбогдох мэргэжлийн байгууллагуудад танилцуулж холбогдох саналуудыг нэгтгэсэн. Гүйцэтгэл -100%
3.	Баримт бичгийн төслийг хянаж байгаа	40	Баримт бичгийг тухайн чиглэлээр мэргэшсэн зөвлөх үйлчилгээний байгууллагуудыг тендер шалгаруулалтаар сонгож гэрээ байгуулсан. Хотын стандартын баримт бичгийн төслийг хянах ажил хийгдэж байна. Гүйцэтгэл -90%
4.	Хүлээгдэж байгаа	6	Уг баримт бичгүүдийг боловсруулах ажлын даалгаврыг 2020.05.25-нд газрын даргаар батлуулж зөвлөх үйлчилгээний тендерийг удаа дараа зарласан боловч амжилтгүй болсноор уг ажлыг 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Гүйцэтгэл -30%
	Нийт	97	Гүйцэтгэл -91,5%

Зураг 1. Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын баримт бичиг Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/456 дугаар тушаалаар мөрдүүлэхээр шийдвэрлэсэн.



1.1.2 Усны нөөцийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг сайжруулан, ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлж зүй зохистой хэрэглээг бий болгох /НЭЗНХҮЧ-ийн 3-40 дэх арга хэмжээ/ ажлын хүрээнд:

“Усан хангамжийн эх үүсвэрийн хориглолт хязгаарлалтын бүсийг хашаажуулах, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлжүүлэх, гэрчилгээ олгох, гэрчилгээжүүлнэ” гэсэн арга хэмжээг Ус сувгийн удирдах газартай хамтран хэрэгжүүлэхээр эдийн засгийн нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан. Хориглолт хязгаарлалтын бүсэд барих хашааны стандарт, норм дүрмийн дагуу загвар, хийц, өнгө, технологийн шаардлага, холбогдох төсвийн тооцоог гарган Ус сувгийн удирдах газарт хүргүүлээд байна.

Усан хангамжийн эх үүсвэрийн хориглолт хязгаарлалтын бүсийг хашаажуулах төсвийг нийслэлийн 2020 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд тусгуулахаар санал хүргүүлсэн боловч төсөвт суугдаагүй тул 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулахаар НЗДТГ-т дахин санал хүргүүлсэн.

1.1.3 Хөрсний бохирдлыг бууруулах бодлого, эрх зүйн орчныг сайжруулах /НЭЗНХҮЧ-ийн 3-43 дахь заалт: ажлын хүрээнд :

Газрын даргын 2020 оны А/01 дүгээр тушаалаар Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 3 агентлагийн төлөөлөл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөл болон НҮБ-ХАБИТАТ байгууллагын төлөөллүүдийг оролцуулсан 25 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсэг судалгааны удирдамж батлуулж төвлөрсөн инженерийн шугамд холбогдох боломжгүй ариун цэврийн байгууламжийн суурь судалгааг хийж дуусган 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн шуурхай хуралд танилцуулсан.

Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хамтран “www.manaikhoroо.mn” цахим системд судалгааны мэдээлэл оруулах “ЦЭС”-ийг шинээр үүсгэн хороодын хэсгийн ахлагч нарт судалгааны мэдээллийг цахим системд оруулах зааварчилгааг утсаар өгөх ажлыг хэлтсийн мэргэжилтнүүд хамтран гүйцэтгэсэн.

Дүүргүүдээс ирүүлсэн судалгааны мэдээлэл

Хүснэгт 2

Д/д	Дүүрэг	manaikhoroo.mn	Файл	Үйл ажиллагааны төрөл				
				Шатахуун түгээх станц	Амралт аялал жуулчлалын газар	Авто засвар, угаалга	Дэлгүүр мухлаг	Бусад үйлдвэр, үйлчилгээ
1	Баянгол	-	38	-	-	12	13	13
2	Баянзүрх	767	812	27	18	78	336	353
3	Багануур	-	66	-	-	5	33	28
4	Багахангай	1	17	-	-	2	6	9
5	Налайх	150	274	8	38	15	118	95
6	Сүхбаатар	138	153	12	-	7	117	17
7	Сонгинохайрхан	297	843	14	9	61	510	249
8	Хан-Уул	48	335	11	10	12	155	147
9	Чингэлтэй	8	539	17	2	51	289	180
10	Байршил тодорхойгүй	163	-	-	-	-	-	-
Нийт		1572	3077	89	77	243	1577	1091

Жич: Нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн 20 зуслан байгааг НГБХЗХГазраас тоон мэдээллээр авч, сургалт хийх байгууллагын тоонд оруулахаар болсон.

“Манай хороо” цахим системд оруулсан судалгааны ажлын мэдээллийг графикаар үзүүлэв.






График 1.1. Манай хороо цахим системд оруулсан судалгааны мэдээлэл

Хөрсний бохирдлыг бууруулах талаарх эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг НИТХ-ын 2019 оны 187 дугаар тогтоолоор байгуулагдсан.

Дээрх ажлын хэсэгт байгууллагын зүгээс дараах хэд хэдэн саналыг

бодлогын баримт бичигт тусгуулахаар албан бичгээр хүргүүлсэн. Үүнд:

- Төвлөрсөн усан хангамжид холбогдох боломжгүй байршилд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийн ариун цэврийн байгууламжийг MNS5924:2015 стандартын шаардлагад нийцүүлэх буюу олон улсын дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн нөхцөлд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгодог байх,
- MNS 5924:2015 стандартын хэрэгжилтийг айл өрх, аж ахуйн нэгжүүдэд хангуулах,
- Ахуйн шингэн хаягдал, соруулан зөөвөрлөн устгах эрх бүхий аж ахуйн нэгжүүдийг төрөөс дэмжлэг үзүүлэн үйл ажиллагааны хүрээг тэлэх арга хэмжээг авах, иргэдийг өрхийн ариун цэврийн байгууламжаа шинэчлэхэд зориулан хүүгүй зээл авах боломжийг бий болгох,
- Ариун цэврийн байгууламжийн стандартын талаарх мэдлэг мэдээллийг олон нийтэд түгээх, дүүрэг хороодод энэ талаар мэдээлэл түгээх идэвхтэн сургагч бэлтгэх

1.1.4 Хот орчмын түгээмэл тархацтай ашигт малтмал болон нүүрсний уурхайн нөхөн сэргээлтийг дэмжих, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд:

НЗД-ын 2020 оны А/449 дугаар захирамжаар Налайх дүүрэг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газарт “Уурхайн эдэлбэр газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх төсөл”-ийн ажлын даалгаварт холбогдох саналыг 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 04/114 дугаар албан бичгээр хүргүүлэн хамтран ажиллаж байна. Үүнд:

1. Нөхөн сэргээлтийн ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын 8.4 хэсгийг баримтлан гүйцэтгэх;
2. Далд уурхайн босоо, налуу, хэвтээ малталтуудын амсрыг цаашид өөр зориулалтаар ашиглах боломжгүй нөхцөлд төмөр-бетон хийц ашиглан битүүмжилж уг хаалтад тултал гадна талаас нь чулуугаар чигжиж уурхайн орчмын газрын гадарга дахь ухсан нүх, ан цавыг дарж бөглөн хэлбэршүүлэн тэгшилж ургамалжуулна;

3. Усанд автахаас сэргийлэх, түүний ойролцоо санамж тэмдэг хийж байршуулах зэрэг саналуудыг хүргүүлэв.

Мөн 2020 оны 07 дугаар сарын 27-ны Налайх дүүргийн Засаг даргын орлогч С.Тунгалагийн баталсан тус дүүргийн хэмжээнд “Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийх” удирдамжийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга Н.Билэгсайхан орж ажилласан.

Зураг 2 Налайх дүүрэг дэх ашигт малтмал олборлогчдын йл ажиллагаатай танилцаж зөвлөмж өгөв.



ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1 Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт:

2020 онд Засгийн газрын 2 тогтоолын 11 заалт, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 1 тогтоолын 1 заалтыг хяналтад авч хэрэгжүүлэн ажилласан. Эдгээрээс бүрэн хэрэгжсэн 10, хэрэгжих шатандаа байгаа буюу 70%-ийн хэрэгжилттэй 2 заалт байгаа бөгөөд хэрэгжилтийн дундаж 95%-тай байна (Хүснэгт 2.1).

Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн байдалд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн байгууллагын хэлтэс, албадын ажлын үр дүнг үнэлэхэд нэг үзүүлэлт болгон ажиллаж байна. Тогтоол шийдвэрийн биелэлт дунджаар 95% байна.

Хүснэгт 2.1. Дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлт.

		Бүгд	ЗГ-ын албан даалгавар	ЗГ-ын тогтоол	НИТХ-ын тогтоол	НИТХ, НИТХТ-ийн тогтоол
Хяналтад авсан тогтоол, шийдвэрийн тоо		3	-	2	-	1
Хяналтад авсан зүйл заалтын тоо		12	-	11	-	1
Үүнээс	Биелсэн 100%	10	-	9	-	1
	Хэрэгжих шатандаа 70%	2	-	2	-	-
	30%	-	-	-	-	-
	0%	-	-	-	-	-

Тасарсан	-	-	-	-	-
Хүчингүй болсон	-	-	-	-	-
Чиг үүрэгт хамааралгүй	-	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй	-	-	-	-	-
Биелэлтийн дүн (%)	95%	-	94.5%	-	100%

2.1.1. Монгол Улсын засгийн газрын тогтоолын хэрэгжилт
Монгол Улсын засгийн газрын “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилт:

- Тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар Нийслэлийн Засаг даргын “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг шилжин ажиллах тухай” А/1016 дугаар захирамжийн дагуу тус газрын албан хаагчид Сүхбаатар дүүргийн 15,17,19 дүгээр хороонд сайжруулсан түлшний борлуулалт түгээлтийн үйл ажиллагаанд 2019 оны 11 сараас 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хяналт тавьж Нийслэлийн Онцгой комисст холбогдох дүн мэдээг нэгтгэн өгөх ажлыг газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хяналт тавьж дүн мэдээг тогтмол нэгтгэн дүүргийн штабд хүргүүлэн ажилласан.
- Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөрийн баталсан удирдамж, хуваарийн дагуу 2019 оны 12 дугаар сарын 31, 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрүүдэд нийслэлийн шуурхай штабт болон дүүргүүдийн шуурхай штабд сайжруулсан түлшний түгээлт, борлуулалт, нөөцлөлтийн талаарх мэдээллийг нэгтгэн, хяналт тавьж хариуцлагатай жижүүрийн үүргийг тус газрын удирдах албан хаагчид 24 цагаар гүйцэтгэв.
- 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Сүхбаатар дүүргийн 15,17,19 дүгээр хорооны айл, өрхөд нийт 1569 ширхэг угаарын хийн мэдрэгч төхөөрөмжийг суурилуулан өгч, танилцуулга, гарын авлага тарааж, аюулгүй ажиллагааны заавар, зөвлөмж өгч ажиллав.



Зураг 2.1. Угаарын хий мэдрэгч ашиглах заавар, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж тарааж байгаа ажлын явц

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж, хяналт тавих тухай” А/1036 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороонд Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Өлзийсайхан, Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Г.Бүтэнбаяр, Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн мэргэжилтэн Д. Мөнх-Эрдэнэ, Сүхбаатар дүүргийн 17 дугаар хороонд Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн мэргэжилтэн У.Санчир, Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Ж.Готов, Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Өсөх-Идэр Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороонд Захиргааны хэлтсийн мэргэжилтэн С.Болдоо, Барилга байгууламжийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн Ц.Тогтохбуян, Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн мэргэжилтэн Ш.Болдбаатар, Газрын жолооч Б.Жамбалсүрэн нийт 10 албан хаагчид 2020 оны 09 дүгээр сарын 15,16 - ны өдрүүдэд тус хороодын айл өрхийн ахуйн хэрэглээний зуухны бүрэн бүтэн байдал, угаарын хий мэдрэгчийн хэвийн ажиллагааг шалгаж, суурилуулан ашиглах заавар зөвлөмжийг нийт 284 айл өрхөд хүргүүлэн өгч гарын үсгээр баталгаажуулан ажиллав.

Хүснэгт №2 Заавар зөвлөмж тараасан тоон мэдээлэл

№	Дүүрэг	Хороо	Хэсэг	Өрхийн тоо	Шинээр угаарын хий мэдрэгч тараах шаардлагатай	Угаарын хий мэдрэгч шалгасан айл өрхийн тоо
1	Сүхбаатар	15	8	142	10	142
		17	10	110	3	110
		19	8	60	11	32
Нийт					24	284

Зураг 1 Айл өрхүүдэд угаарын хийн төхөөрөмж суурьлуулж байгаа нь:



Сүхбаатар дүүргийн 15,17,19 дүгээр хороонд Хот тохижилтын асуудал хариуцсан мэргэжилтэн У.Санчир, Инженерийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн Д.Мөнх -Эрдэнэ Газрын жолооч Б.Жамбалсүрэн нар 2020 оны 10 дүгээр сарын 08, 20 -ны өдрүүдэд сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэг, нөөцийн мэдээ, угаарын хий мэдрэгчийн бүрэн бүтэн байдал галлагааны зөвлөмж зааврыг айл өрхүүдэд өгч ажиллагааны мэдээг хяналт тавин ажилласан.



Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж, хяналт тавих тухай” А/1036 дугаар захирамжийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 15,17,19 дүгээр хороодын борлуулалт, дундын цэгүүдэд байнгын хяналт тавьж, угаарын хий мэдрэгч, зөвлөмж тарааж ажиллах албан хаагчдын хуваарийг гарган айл өрхүүдэд мэдрэгч болон “Зуух пийшин, яндангийн бүрэн бүтэн байдал, галлагаанд тавигдах шаардлага”-ын эмхэтгэлийг тараах ажлыг гүйцэтгэсэн.

БАТЛАВ
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА,
... Ю ОДЖАРГАЛ

Хяналтын 01 дугаар сарын 23-ны өдөр

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020 ОНЫ А/1036 ДУГААР ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД
СҮХБААТАР ДҮҮРГИЙН 15,17,19 ДҮГЭЭР ХОРООДЫН САЙЖРУУЛСАН ШАХМАЛ ТҮЛШИЙ ДУНДЫН АГУУЛАХ, БОРЛУУЛАЛТЫН ЦЭГҮҮДЭД
БАЙНГЫН ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ АЛБАН ХААГЧДЫН ХУВААРЬ

Дүүрг	Хороо	Тайлан мэдээ нэгтгэх	Хяналт тавьж ажиллах албан хаагчдын нэр		Цэгийн дугаар	Сайжруулсан шахмал түлшний дундын агуулах борлуулалтын цэгийн байршил	Хорооны Засаг дарга, зохион байгууллагчийн нэр, утасны дугаар
			Ахлагч	Гишүүд			
Сүхбаатар	15	Д.ӨЛЗИСАЙХАН /Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн/ С.ОЮУНСҮРЭН /МТХ мэргэжилтэн/ 90966009	Д.МӨНХ-ЭРГЭНЭ /ОАБХХ мэргэжилтэн/ З.ГЭРЭЛТ-ОД /СХХ мэргэжилтэн/ С.ОЮУНСҮРЭН /МТХ мэргэжилтэн/	221	Дамбадаржаа 20-36 Б Баасансүрэн /86861112/	Ц.Сарантуяа /СБД-ийн 15 дугаар хорооны Засаг дарга/ 99218951 Г.Энхдагуул /СБД-ийн 15 дугаар хорооны Зохион байгуулагч/ 6883343	
				116	Дамбадаржаа-82-107 тоот "Өлзий" мухага М.Бат-Өлзий /99145134/		
				296	Ар хустайн 2-235 тоот Жаргалсайхан /86848888/		
	17	С.БОЛДОО /Захирааны хэлтсийн мэргэжилтэн/ 89098827	Ш.БОЛДБААТАР /ОАБХХ мэргэжилтэн/ А.ЭНХЗАЯА /МТХ мэргэжилтэн/	Дундын агуулах	Дамбадаржаа 2-13-3 1-р хэсэг С.Амгалан /89933519/	Г.Даваазцэг /СБД-ийн 17 дугаар хорооны Засаг дарга/ 89084681 Г.Алтанцэцэг /СБД-ийн 17 дугаар хорооны Зохион байгуулагч/ 68631558	
				60	Дамбадаржаагийн 60-р гудамжны 833 тоот Сэржмадаг /80057969, 89592891/		
	19	О.РЭНЦЭНДОРЖ /Мэдээлэл технологийн хэлтсийн дарга/ 99106611	Г.БҮТЭНБАЯР /СХХ мэргэжилтэн/ Д.БАТЧИМ /ББХХ мэргэжилтэн/	161	Дамбадаржаа 35-4556 тоот Ж.Доржиготов /89134216, 88645544/	Ш.Батдорж /СБД-ийн 19 дугаар хорооны Засаг дарга/ 99132849 Э.Галбалд /СБД-ийн 19 дугаар хорооны Зохион байгуулагч/ 91170034	
211				Дамбадаржаагийн Амгалан орон сууцны 49 Нарчин-Иш /86404111/			
365				Хуурай мухага 18 М.Төмөрбаяр /84630867, 89739719/			

ХЯНАСАН:
ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
БОЛОВСРУУЛСАН
ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ӨЛЗИСАЙХАН
У.САНЧИР

ХОТ

ЦЭВЭР АГААР, ЭРҮҮЛ ОРЧИН

Зуух, пийшин, яндангийн бүрэн бүтэн байдал, галлагаанд тавигдах шаардлага

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилт:

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын Төрийн захиргааны албан хаагчид, хэлтэс, газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”-ын хүрээнд улирал, хагас жил, бүтэн жилээр боловсруулж баталгаажуулан ажиллав.

№	хугацаа	Гүйцэтгэлийн тайлан үнэлүүлсэн албан хаагчийн тоо	Олгосон урамшууллын дүн /мян, төгрөг/	Үнэлгээний дундаж
1	1-р улирал	17	5,363,8	89.4

2	2-р улирал	16	5,256,8	89.8
3	3-р улирал	27	7.895.4	89.9
4	4-р улирал	40	11,792,3	93.3

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилт:

Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай“ Тогтоолоор хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 10 үүрэг даалгавар өгөгдсөн. Үүнээс 8 үүрэг даалгавар 100 хувийн биелэлттэй. 2 үүрэг даалгавар 70 хувийн биелэлттэй хэрэгжих шатандаа байна.

2.2 Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийслэлийн Засаг даргын 16 захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 7 хуралдааны тэмдэглэл, нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэлээс өгсөн 14 үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, биелэлтийг нэгтгэн нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” журмын дагуу L-monitoring программд нэгтгэн орууллаа. Биелэлтийн дундаж 90.9%-тай байна. Мөн нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 15 ажлын хэсэгт ажиллаж байна (Хүснэгт 2.3).

Хүснэгт 2.2. Дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлт.

		Бүгд	Засаг даргын захирамж	Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл	Нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл	
Хяналтад авсан тогтоол, шийдвэрийн тоо		36	15	7	14	
Хяналтад авсан зүйл заалтын тоо		43	18	11	14	
Үүнээс	Биелсэн 100%	30	13	9	8	
	Хэрэгжих шатандаа	70%	13	5	2	6
		30%	-	-	-	-
		0%	-	-	-	-
		Тасарсан	-	-	-	-
	Хүчингүй болсон	-	-	-	-	
	Чиг үүрэгт хамааралгүй	-	-	-	-	
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй	-	-	-	-	
Биелэлтийн дүн (%)		90.9%	91.6%	94.5%	87.1%	

Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хугацаа хоцроолгүй www.ulaanbaatar.mn, нутгийн захиргааны ер системд тухай бүр тайлагнан ажиллалаа.

Д/д	2020 онд болсон шуурхай хурал	Өгөгдсөн үүрэг даалгаврын тоо		Биелэлтийн хувийн
		Үүнээс		
		Нийт үүрэг даалгавар	Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой	
1	11	59	8	92.5 хувь

Хүснэгт 2.3. Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	НЗД-ын захирамжийн дугаар	Захирамжийн нэр	Ажилласан албан хаагч	Хүрсэн үр дүн
1	Засгийн газрын 2018 оны 73 дугаар тогтоол	“Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийн талаар зарим арга хэмжээний тухай”	Орлогч дарга	Нийслэлийн Засаг даргаас 2020 оны 04 дүгээр сар 28-ны өдөр Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт тус тус үүрэг өгөгдсөний дагуу ажлын хэсэг 4 удаа хуралдсан. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд асуудлыг танилцуулж буцаагдсан ба Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчийн Тэргүүлэгчдийн хурлаар дахин хэлэлцүүлэхээр болсон.
2	Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/609 дугаар захирамж	“Газар барилгажилтын мэргэжлийн зөвлөлийн хурал”	СХХ-ийн дарга	24 удаагийн хуралд оролцож байгууллагын чиг үүргийн хүрээнд санал өгч ажилласан.
3	Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1246 дугаар захирамж	“Ажлын хэсэг байгуулах тухай”	Газрын дарга	Удирдамжийн дагуу шалгалтыг хийж санал, дүгнэлтийг 2020 оны 02 сарын 07-ны өдөр НЗДТГ-т хүргүүлсэн.
4	Нийслэлийн засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/1343 дугаар захирамж	“Болзолт уралдаан зохион байгуулах тухай”	Газрын дарга	“Нэг хот нэг стандарт” болзолт уралдаан амжилттай зохион байгуулагдаж байгаа бөгөөд 1-р улирлын байдлаар дүгнэж шагналыг гардуулсан. Болзолт уралдаан үргэлжлэн зохион байгуулагдаж байна.
5	Нийслэлийн засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/1343 дугаар захирамж	“Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт, үнэлгээ хийх ажлын хэсэг	Газрын дарга, ОАБХХ-ийн дарга	Удирдамжийн дагуу ажлын хэсэгт ажиллаж нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2019 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж тайлан мэдээг НЗДТГ-т хүргүүлсэн
6	Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1205 дугаар захирамж	“Сайжруулсан түлшний үнсийг дахин ашиглах” талаар санал танилцуулах ажлын хэсэг	ОАБХХ-ийн дарга	Үнсийг орлуулан явган замын хавтан, эко хавтан, борьдюр, зэргийг хийх туршилт явуулсан. 2020 оны 3-р сарын 3-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/286 дугаар Захирамжаар шийдвэрлэж өгсөн.

7	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/545 дугаар захирамж	“Сэлбэ дэд төвийн дулааны станцын барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх” ажлын хэсэг	ОАБХХ-ийн дарга	Сэлбэ дэд төвийн 28МВт/ц хүчин чадалтай дулааны станцын угсралтын ажил 65%-ийн гүйцэтгэлтэй байна.
8	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 10 -ны өдрийн А/924 дүгээр захирамж	“Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны талаар”	БТХ-ийн дарга	Уг ажлын хүрээнд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж байгаа Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төслийн 2 дугаар хэсгийн хүрээнд төлөвлөгдсөн Улаанбаатар хотын барилга эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах зорилготой. 2020 оны эхний хагас жилийн байдлаар
9	А/922 Нийслэлийн Засаг даргын захирамж	“Авто замын түгжрэлийг бууруулах, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хэсэг”	Газрын дарга	Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах шаардлага /UCS 0902В:2020/ -Хотын стандартын бичиг баримтыг боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.
10	2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/169 дугаар захирамж	“Ажлын хэсэг байгуулах тухай”	Газрын дарга	Барилгын үндэсний ассоциацитай хамтарсан ажлын хэсгийн хурал 1 хуралдаж газрын орлогч дарга оролцсон.
11	2020 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн А/318 дугаар захирамж	“Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар боловсруулах ажлын хэсэг”	Газрын дарга	Ажлын даалгаварт тусгах саналыг 2020 оны 03/97 дугаар албан бичгээр НГЗБА-д хүргүүлсэн.
12	2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/397 дугаар захирамж	“Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зуслангийн 26 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол” хийх ажлын хэсэг	СХХ-ийн дарга	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зуслангийн 26 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийх зургийн даалгаврын төсөлд 10 чиглэл бүхий санал боловсруулж 2020.04.03-ны өдрийн 02/101 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Ажлын хэсгийн хурал 1 удаа оролцож санал солилцсон.
13	Ерөнхий менежерийн 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/70 дугаар тушаал	“Хот нийтийн аж ахуйн ажилд захиалагчийн хяналт тавьж, ашиглалтад хүлээн авах комисс байгуулах тухай” ажлын хэсэг	МТХ-ийн ахлах мэргэжилтэн	Хот нийтийн аж ахуйн ажилд захиалагчийн хяналт тавьж гүйцэтгэсэн ажлыг байнгын ашиглалтад хүлээн авах комисст гишүүнээр ажиллан 10 багц ажлыг байнгын ашиглалтад хүлээж авсан.
14	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2020 оны А/80 дугаар тушаал	“Гадна зар сурталчилгааны зөвлөлийн гишүүдийг шинэчлэн батлах тухай” ажлын хэсэг	СХХ-ийн дарга	Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд 2020.04.02-оос 04.14-ны хооронд барилга байгууламжийн дээвэр, ханан дээр байрлах зар сурталчилгааны самбарыг нэгдсэн стандартад оруулах ажлын хүрээнд 1104ш самбарын судалгаа хийсэн.

15	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/646 дугаар захирамж	Ажлын хэсэг байгуулах тухай	Газрын дарга	Ажлын хэсгийн хуралд 2 удаа оролцсон. Ажлын хэсгийн гишүүд 2017-2020 оны НЗДТГ-ын ХШҮХ-н тайлан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээтэй танилцаж дүгнэлт гаргахаар шийдвэрлэсэн. Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.
16	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1292 дугаар захирамж	Мэргэжлийн зөвлөлийн хурлын бүрэлдэхүүн батлах тухай	Газрын дарга	Мэргэжлийн зөвлөлийн хуралд сууж хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт асууж санал, дүгнэлт өгч ажилласан.

2.3 “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил:

“Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн төлөвлөгөөний төсөлд хариуцан хэрэгжүүлэх ажлын санал боловсруулан нэгтгэж 11 зорилт арга хэмжээг үндсэн хариуцагчаар, 25 зорилт арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдаж эдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар үе шаттай ажлыг зохион байгуулж байна. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар 90,5% иар дүгнэсэн байна. Тус төлөвлөгөөнд тусгагдаж хэрэгжилт дутуу зарим арга хэмжээг байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

“Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд тус газраас дараах хэд хэдэн онцлох ажлыг гүйцэтгэв.

- “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн нээлтийн зөвлөгөөнийг нийслэлийн нутгийн захиргааны нийт албан хаагчдын зохион байгуулахаар Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/95 дугаар захирамжийн хүрээнд зөвлөгөөнд хэрэглэх тараах материал болох хотын стандартын баримт бичиг, зорилтот жилийн тэмдэглэлийн дэвтэр зэргийн эх загварыг боловсруулах, хэвлүүлэх, шаардлагатай төсвийн тооцоо гаргах, хөтөлбөр боловсруулах зэрэг бэлтгэл ажлыг бүрэн хангасан боловч Шинэ коронавирүс /Covid-19/-ийн халдварын дэгдэлтийн улмаас улсын хэмжээнд онц байдал зарлаж уг арга хэмжээг зохион байгуулах боломжгүй болсон. Тус арга хэмжээний хүрээнд нийт нутгийн захиргааны байгууллагуудад танилцуулах сургалтын материал, Хотын стандартын баримт бичиг, “Нэг хот-нэг стандарт” зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлт гаргах, үнэлэх арга зүй гэх мэт асуудлаар холбогдох байгууллага, албан хаагчдад танилцуулж заавар, зөвлөмж өгөх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулсан.
- Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Болзолт уралдаан зарлах тухай” А/1343 дугаар захирамжийн дагуу болзолт уралдааныг дүгнэх ажлын хэсэгт ажиллаж удирдамж, шалгуур үзүүлэлтийг нутгийн захиргааны байгууллагуудад танилцуулсан. Удирдамжид заасан шалгуур үзүүлэлтийн дагуу нийслэлийн нутгийн захиргаа, харьяа байгууллагуудын тайлантай улирал бүр нэг бүрчлэн танилцаж төлөвлөгөөний хэрэгжилт, уралдааныг

дүгнэх асуудлаар санал дүгнэлт гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлж ажиллав.

- Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг болон харьяа 31 байгууллагын 85-н удирдах албан тушаалтан, нийслэлийн 9 дүүргийн 107 удирдах албан тушаалтанд Хотын стандартын баримт бичгийн тогтолцоо, стандартын талаарх танилцуулга сургалтыг 5 бүлэг сэдвийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Удирдлагын академи, Хот байгуулалт хөгжлийн газартай хамтран 2020 оны 04 дүгээр сарын 27-оос 05 сарын 01, 05 дугаар сарын 12-оос 14-ний өдрүүдэд зохион байгуулан ажилласан.



Зураг 2.2. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хийсэн сургалт

- “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилд нийслэлийн хэмжээнд зохион байгуулж буй арга хэмжээг олон нийтэд сурталчлах, мэдээллээр хангах зорилгоор 11 бүлэг сэдвийн хүрээнд 47 арга хэмжээ бүхий хэвлэл, мэдээллийн ажлын төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргаар 2020 оны 03 дугаар сарын 09-нд батлуулж төлөвлөгөө ёсоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран зорилтот жилийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд зорилтот жилийн үйл ажиллагаатай холбоотой

“Нэг хот – нэг стандарт” болзолт уралдаан

Хотын стандарт, норм, дүрэм, хэм хэмжээг мөрдүүлэх хяналтын тогтолцоог сайжруулах, иргэдийн амьдрах орчныг сайжруулахад хороо, хэсгийн ахлагч нарын үйл ажиллагааг чиглүүлэх зорилгоор “Нэг хот-Нэг стандарт” болзолт уралдааныг зохион байгуулах тухай шийдвэр НЗД-ын 2019 оны “Болзолт уралдаан зарлах тухай” А/1343 дугаар захирамжаар гарсан.



Зураг 2.3. Болзолт уралдааны талаар танилцуулга сургалт

Захирамжийн хэрэгжилтийг хангуулах, Шилдэг хороо, Шилдэг хэсгийн ахлагч нарыг шалгаруулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор www.manaikhoroo.mn цахим системийн ашиглалт, үйл ажиллагааг танилцуулах сургалтыг нийслэлийн 9 дүүргийн 173 хорооны зохион байгуулагч, нийгмийн ажилтнуудад 2020 оны 01 дүгээр сарын 16-аас 21-ний өдрүүдэд зохион байгуулав. Сургалтыг Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Азийн сан болон www.manaikhoroo.mn –ийг хөгжүүлэгч компани болох Хан Хөлгөн ХХК-тай хамтран зохион байгуулсан.


2020 оны 04 дүгээр сарын 04-16-ын өдрүүдэд нийслэлийн 44 хороонд ажиллаж www.manaikhoroo.mn цахим сайтаар дамжуулан зөрчил мэдээллийг бүртгэсэн байдал, шийдвэрлэсэн арга хэмжээ, 1 дүгээр улирлын үйл ажиллагааны биелэлт, зохион байгуулсан арга хэмжээнд үнэлэлт, дүгнэлт өгч хороо, хэсгийн ахлагч нарын багийн үйл ажиллагаатай танилцаж заавар, зөвлөгөө өгч ажиллав.



Зураг 2.4. Болзолт уралдааны дүн шалгаруулалт

Шилдэг хороо, шилдэг хэсгийн ахлагч нарыг шалгаруулахад Хороо, хэсгийн ахлагч нарын багаас ирүүлсэн зөрчил мэдээллийг www.manaikhoroo.mn цахим системд бүртгүүлсэн байдал, системийн ашиглалтын явц, шийдвэрлэлтийн мэдээллээр үнэлж дүгнэн мэдээллийг нэгтгэж улирал бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.

Манай хороо www.manaikhoroo.mn цахим хуудсанд 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд **4955** зөрчлийн мэдээллүүд бүртгэгдсэн ба үүнээс шийдвэрлэсэн зөрчлийн тоо **1564** буюу нийт зөрчлийн **32%**-ийг шийдвэрлэсэн байна. Харин шийдвэрлээгүй буюу хүлээгдэж байгаа нийт **3391** зөрчил буюу **68%**-ийг шийдвэрлээгүй байна.



Болзолт уралдааны удирдамжийн дагуу тэргүүний 10 хороо, 10 хэсгийн ахлагч нар шалгарч тэргүүний хороо, хэсгийн ахлагч нарын багт шагналыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайхан 2020 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 24 -ний өдрүүдэд гардуулан өгсөн.



Зураг 2.5. Болзолт уралдааны дүн шалгаруулалт



Зураг 2.6. Нэг хот-нэг стандарт болзолт уралдаанд түрүүлсэн хэсгийн ахлагч нар

2.4 Нийслэлийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

2020 оны туршид Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн зохион байгуулагдаж тус газрын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар нийт 59 удаагийн үүрэг даалгавар өгөгдснөөс тус газрын үндсэн үйл ажиллагаатай холбогдох, тухайлсан шинж чанартай 8 үүрэг даалгавар байв. Эдгээр үүрэг даалгаврын хэрэгжилт 92,5 хувьтай бөгөөд хугацаа хэтэрсэн болон хэрэгжилт хангалтгүй гэх зөрчилгүй ажиллав.

Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хугацаа хоцроолгүй www.ulaanbaatar.mn, нутгийн захиргааны ер системд тухай бүр тайлагнан ажиллалаа.

НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ХУРАЛДААНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

Огноо, өгөгдсөн үүрэг даалгавар	Хэрэгжилт
<p>2020.01.06</p> <p>Хотын стандарт, норм, дүрмийн талаарх мэдлэг ойлголтыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд түгээн хэвшүүлэх замаар тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, хотын стандартыг мөрдүүлэхэд бүх нийтийн оролцоог хангуулж ажиллах.</p>	<p>Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг чанар, стандарт, норм, дүрмийг хангуулах, хугацаандаа гүйцэтгүүлэхийг анхаарч хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон стандарт, нормыг хангасан тоног төхөөрөмжтэй аж ахуй нэгжүүд тендерийн үйл ажиллагаанд давуу талтай байхаар тооцож худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газар, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газарт тус тус үүрэг өгсөн.</p> <p>Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичигт стандарт, норм, дүрмийг тусгах, чанартай гүйцэтгүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн авто замын хөгжлийн газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газруудтай 4 удаагийн хурал зохион байгуулсан. Хурлын</p>

	<p>шийдвэрийн үр дүнд 2020 оны хагас жилийн байдлаар 14 нэр төрлийн хотын стандартын баримт бичгийг 304 төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагааны тендер сонгон шалгаруулалтын жишиг бичиг баримтад давхардсан тоогоор 542 нэр, төрлийн хотын стандарт, норм, дүрмийг тусгуулж ажилласан байна.</p>
<p>2020.01.06 Нутгийн захиргааны байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэх, олон улсын жишигт нийцсэн стандарт, техникийн зохицуулалтын баримт бичгийг боловсруулж, стандартын талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах.</p>	<p>Нийслэлийн 2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасны дагуу хотын стандарт, техник, зохицуулалтын баримт бичгийг боловсруулах ажлын хүрээнд эхний 16 бүлэг сэдвийн хүрээнд олон улсын болон үндэсний стандарт, норм, нормативыг судлах судалгааны ажил хийгдэж байна.</p> <p>Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Азийн сантай хамтран нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1343 дугаар захирамжийн хүрээнд Болзолт уралдааны талаарх танилцуулга мэдээлэл хүргэх зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, дүүрэг, хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нарын үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагад хороодын зохион байгуулагч нийгмийн ажилтануудын дунд Болзолт уралдааны талаарх танилцуулга сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.</p>
<p>2020.01.20 Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/01 дугаар захирамжаар 2020 оныг “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жил болгон зарласантай холбогдуулан энэ сардаа багтаан зорилтот жилийн нээлтний үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах</p>	<p>“Нэг хот-нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах нийслэлийн төрийн албан хаагчдын нээлтний зөвлөгөөний хөтөлбөр, бэлтгэл ажлын төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж бэлтгэл ажил хангахтай холбоотой дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Нээлтний зөвлөгөөний хөтөлбөрийг боловсруулан удирдлагуудад танилцуулав. -Зөвлөгөөний үеэр оролцогч төрийн албан хаагчдад олгох гарын авлага, тараах материалын эх загварыг боловсруулан, нэгдсэн төлөвлөгөөний төсөлд санал өгсөн. <p>Нээлтний зөвлөгөөний бэлтгэл хангах талаар нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газар, дүүргүүдийн ЗДТГ-уудад НЗДТГ-ын даргын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03/435 дугаар албан бичгээр зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн, үр нөлөөг харуулсан танилцуулга, мэдээ бэлтгэх талаар үүрэг, чиглэлийг өгсөн. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108 дугаар захирамжаар олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хойшлуулсантай холбогдуулан уг арга хэмжээг тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.</p>
<p>2020.02.03 2020 оныг “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд худалдан авах ажиллагааны шаардлагад нийцсэн, барилга, байгууламж, хайс хашлага, тэмдэг, тэмдэглэгээ, тохижилт, авто зогсоолын стандарт болон бусад чиглэлийн стандартыг боловсруулж Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллах.</p>	<p>Үүрэг даалгаврын хүрээнд дараах 3 үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллалаа.</p> <ol style="list-style-type: none"> 1. “Тээврийн хэрэгслийн зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага”-ын стандартын баримт бичгийг боловсруулсан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахад бэлэн болгосон Түүнээс гадна хот тохижилт, явган хүний зам, талбай, замын хэвтээ болон босоо тэмдэг тэмдэглэгээ гэх мэт 16 бүлэг хотын стандарт, техник, зохицуулалтын баримт бичгийн эмхэтгэл гаргахаар олон улсын болон үндэсний стандарт, норм, нормативыг судалж ажлын даалгавар боловсруулах ажил хийгдэж байна. 2. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд нийслэлийн Засаг даргын 2020 оны “Эрх шилжүүлэх тухай” А/48 дугаар захирамжийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа 61 төсөл арга хэмжээнд гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг хянах, хүлээн авах ажиллагаанд тусгаж, хэрэгжүүлэн ажиллавал зохих 11 төрлийн 52 үндэсний стандарт, 91 барилгын норм ба дүрмийн нэр, техник зохицуулалтын ерөнхий шаардлагуудын мэдээллийн жагсаалтыг

	<p>хүргүүлсэн.</p> <p>3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тухайн ажилд холбогдох стандарт, норм, дүрмийн зохих шаардлага, хөдөлмөрийн болон техникийн аюулгүй ажиллагааны заавар зэргийг тендерийн баримт бичигт тодорхой тусгаж байх талаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Авто зам хөгжлийн газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-тай хамтран 4 удаагийн хурал зохион байгуулсан. Тус хурлаар дараах шийдвэрт хүрсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгийн бүрдэлд захиалагч байгууллагаас техникийн тодорхойлолтод ажлын тоо хэмжээ, цар хүрээг тодорхойлох - Хот байгуулалт хөгжлийн газраас архитектур төлөвлөлтийн даалгаварт стандарт, норм дүрэм бусад мэдээллийг нарийвчлан тусгах - Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар нь захиалагчийн хяналтыг тогтмол тавих бөгөөд мөн шаардлагатай тохиолдолд Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газартай хамтран ажиллах - Гэрээний дагуу хийгдэж буй ажилд гүйцэтгэлийн чанар үр дүн, ажлыг хүлээж авч байнгын ашиглалтанд оруулах комиссд Хотын стандарт орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газраас төлөөлөл оролцож байх
<p>2020.02.17 2020 оныг “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлуудаа эрчимжүүлэх. Үүнд: • Барилга, байгууламж, хайс хашлага, тэмдэг, тэмдэглэгээ, • Тохижилт, авто зогсоолын стандарт болон бусад чиглэлийн стандартыг боловсруулах</p>	<p>Нийслэлийн засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 27-ны удирдлагуудад өгсөн шуурхай үүрэг, газрын даргын чиглэлийн дагуу гудамжны нэр, чиглэлийн самбарыг олон улсын стандартын дагуу шинэчлэх ажлын хүрээнд гудамжны чиглэл заасан тэмдгийн стандарт загварын ажлын зураг, харагдах байдлын зургийг боловсруулж 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулсан.</p>
<p>2020.12.17 Шинэ коронавирусийн халдвар, томуу, томуу төст өвчний тархалтаас сэргийлж орчноо бохирдуулахгүй байх анхааруулга, зөвлөмж, зөвлөгөө өгөх үүрэг бүхий эргүүл, жижүүр ажиллуулах хуваарийг боловсруулан батлуулах.</p>	<p>Үүрэг даалгаврын хүрээнд шинэ коронавирусийн халдвар, томуу, томуу төст өвчний тархалтаас сэргийлэх, зөвлөмж, зөвлөгөө өгөх үүрэг бүхий эргүүл ажиллуулах хуваарийг гарган Нийслэлийн Онцгой комиссын Орлогч даргад 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр танилцуулан батлуулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020.02.18-ны өдрийн 03/843 дугаар албан бичгээр нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд эргүүлийн үүрэг гүйцэтгэх газрын байршлыг хуваарилан нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагууд, харъяа төсөвт байгууллага аж ахуйн тооцоот газрууд нийт 71 байгууллагад хүргүүлсэн.</p>
<p>2020.07.09 Баярын өдрүүдэд хүүхдүүдийг болзошгүй үер усны осол, эндэгдлээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлуудыг сайтар зохион байгуулах.</p>	<p>Баярын өдрүүдэд хүүхдүүдийг болзошгүй үер усны осол, эндэгдлээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулан Нийслэлийн шуурхай албаны 11-310005 дугаарын утасанд цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг өгч ажиллав.</p>
<p>2020.07.09 Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, далан сувгийн цэвэрлэгээний</p>	<p>Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах далан сувгийн цэвэрлэгээ, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хийц бүтцийг өөрчилж, барилга барьсан аж ахуйн нэгж байгууллагуудад газрын Орлогч дарга О.Оджаргалаар ахлуулсан ажлын хэсэг дээр нь очиж үзлэг шалгалтыг 2020.07.10-2020.07.17-ны</p>

<p>ажлуудыг шуурхай зохион байгуулж ажиллах, Үерийн далан сувгийг хааж барилга, байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авч, цэгцлэх ажлуудыг шуурхай зохион байгуулж ажиллах.</p>	<p>өдрүүдэд хийсэн.Ажлын хэсэг үзлэг шалгалтаар давхардсан тоогоор нийт 140 зөрчил дутагдлыг илрүүлсэн.Үүнээс: -Барилгын хийц өөрчилсөн-17 -Бүтээн байгуулалтын үед далан сувагт гэмтэл учруулсан-10 -Зөвшөөрөлгүй барилга барьсан-8 -Далан суваг хааж үйл ажиллагаа явуулж буй барилга-12 -Үерийн хамгаалалтын ойролцоо барилгын зөвшөөрөл олгогдсон-23</p>
---	---

2.5. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулах 2019 оны үр дүнгийн гэрээ, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт:

Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээний хавсралт болох байгууллагын 2020 гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулж, батлуулсан. Батлагдсан үр дүнгийн гэрээний дагуу төсвийн шууд захирагч нийт 2,4 тэрбум төгрөгийн урсгал төсвийг захиран зарцуулахаас Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/199 дүгээр захирамжаар 1,5 тэрбум төгрөгийн задаргааг батлуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас жил бүрээр дүгнэн биелэлтийг зохих хугацаанд хүргүүлсэн бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар үр дүнгийн гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 91,5%-тай гэж мэдээлсэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ:


БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Тус газар нь батлагдсан дүрмийн хүрээнд Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор Хот төлөвлөлт, Хот нийтийн аж ахуй, Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, зохион байгуулалт, менежментийн чиглэлээр үндсэн 9 чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэсэн ажлын мэдээг дараах байдлаар тайлагнав.

3.1 Стандарт, норм, дүрэм, орчны аюулгүй байдлын судалгаа

3.1.1 Стандарт, норм, дүрмийн судалгаа

Хотын стандартын баримт бичиг боловсруулахад шаардлагатай суурь мэдээлэл цуглуулан (Олон улсын стандарт 25, Үндэсний стандарт-76, Барилгын норм ба дүрэм 43) дүн шинжилгээ хийж Хотын стандартын баримт бичгийн агуулгыг тодорхойлж Хотын стандартын 97 баримт бичгийн дэлгэрэнгүй зураглал, бүртгэлийн дугаарлалтын системийг боловсруулсан.



Зураг 3.1. Хотын стандартын 97 баримт бичгийн дэлгэрэнгүй зураглал, бүртгэлийн дугаарлалт

3.1.2 Орчны аюулгүй байдлын эрсдэлийн судалгаа

Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлын эрсдэлийн суурь судалгааг гүйцэтгэж түүний үр дүнгээр Иргэдийн амьдрах орчинд эрсдэл учруулахуйц 5423 зөрчилтэй тохиолдлыг бүртгэсэн. Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг хангахад чиглэсэн зарим арга хэмжээ авах тухай” 05 албан даалгаврын дагуу 2019 оны 07 дугаар сараас эхлэн дээрх зөрчлийг арилгах арга хэмжээний үр дүнг тодорхойлох зорилгоор 2020 оны эхний хагас жилд дараах хэд хэдэн үзүүлэлтээр тоон судалгаа хийсэн. Үүнд:

№	Судалгааны чиглэл	Үр дүн	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Manaikhoroo.mn цахим судалгаа, зөрчлийн бүртгэл	4955	Зөрчлийг арилгах талаар сургалт зохион байгуулах, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан.
2	Орчны аюулгүй байдал алдагдсан барилга	576	Барилгын гадна орчны аюулгүй байдлын талаарх судалгааг НЗД-ын Зөвлөлийн хуралд танилцуулж нийслэлийн хэмжээнд “Хашаа” арга хэмжээг зохион байгуулсан.
3	Хөрс бохирдлуулагч стандартад нийцээгүй бие засах газар	3077	Бие засах газруудын стандартыг хангуулах чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай
4	Зөвшөөрөлгүй барилга	95	Сонсох ажиллагаанд хамруулахаар ХБХГ-т санал хүргүүлсэн.
5	Гадна зар сурталчилгааны байгууламж	1104	Шаардлага хангаагүй 239 ш сурталчилгааны самбар байгаа судалгааг гаргасан.
6	Хүүхдийн тоглоомын талбайн стандарт	302	Стандартын шаардлага хангаагүй хүүхдийн тоглоомын талбайн судалгааг гарган УБЗАА-д хүргүүлсэн. НЗД-ын 2020 оны 02 дугаар албан даалгаврын дагуу дахин

			судалгаа хийгдэж байна.
--	--	--	-------------------------

3.2 Хотын стандартын баримт бичиг боловсруулах

Нийслэлийн хот төлөвлөлт, хот байгуулалт, барилга дэд бүтэц, хот нийтийн аж ахуйн салбарт хамаарах нийт 22 бүлэг 97 төрлийн Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын баримт бичиг боловсруулахаар төлөвлөгдсөн. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, ажил үйлчилгээний захиалагч, гүйцэтгэгч болон хяналт тавих эрх бүхий аливаа хувь хүн, хуулийн этгээд, иргэд олон нийтэд зориулан стандартын хэрэгжилтийг дараах үе шат бүхэнд хангуулахад удирдамж, заавар болсноороо онцлогтой юм. Үүнд:

- Ажил үйлчилгээ, төсөл арга хэмжээг төлөвлөх,
- Ажлыг гүйцэтгэх,
- Хяналт тавих
- Ажил, үйлчилгээг хүлээн авах, чанарын шаардлага хангуулах
- Ашилалт, засвар үйлчилгээ

Хотын стандартын баримт бичиг нь Техникийн шаардлага, материалын шинж чанар, Хийц технологи, шалгуур үзүүлэлт, Ашиглалт, засвар үйлчилгээнд тавигдах шаардлага гэсэн үндсэн бүтэцтэй бөгөөд жишээ зураглал, схемээр тайлбарласан.

Хотын стандартын удирдамж арга зүйн 22 бүлгийн 97 баримт бичгийг боловсруулах ажлыг 3 үе шаттайгаар зохион байгуулсан.

Нэгдүгээр үе шат: Нийслэлийн хот тохижилт, бүтээн байгуулалтын ажил, үйлчилгээнд нэн тэргүүнд мөрдүүлэх шаардлагатай 14 сэдвийн хүрээнд холбогдох стандарт, норм, дүрмийн суурь судалгааг нэгтгэн хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг боловсруулсан.

Эдгээр 14 төрлийн хотын стандартын баримт бичгийг Нийслэлийн засаг даргаар 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр “Хотын стандартын баримт бичгийг мөрдүүлэх тухай” А/456 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд мөрдүүлэхээр шийдвэрлүүлсэн. Үүнд:

Хотын стандартын баримт бичгийн нэр, код

1. Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага /UCS0001-01:2019/
2. Хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ /UCS0001-02:2019/
3. Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчны бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага /UCS0002-02:2019/
4. Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага /UCS 0901B:2020/
5. Унадаг дугуйн замыг төлөвлөлтөд тавигдах шаардлага /UCS 0903B:2020/
6. Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах шаардлага /UCS 0902B:2020/

7. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага /UCS 1404B:2020/
8. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах хогны саванд тавигдах шаардлага /UCS 1403C:2020/
9. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага /UCS 1901B:2020/
10. Нийтийн тээврийн үйлчилгээнд тавигдах шаардлага /UCS 1601C:2020/
11. Хүүхдийн автобусанд тавигдах шаардлага /UCS 1602C:2020/
12. Нийтийн тээврийн автобусны зогсоолд тавигдах шаардлага /UCS 1601B:2020/
13. Такси үйлчилгээнд тавигдах шаардлага /UCS 1603C:2020/
14. Таксины зогсоол тавигдах шаардлага /UCS 1602B:2020/

Нийслэлийн 9 дүүрэг, холбогдох мэргэжлийн байгууллагуудад улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх хот тохижилт, бүтээн байгуулалтын ажилд стандартын дагуу чанартай гүйцэтгүүлэхэд хэрэглэх 14 нэр төрлийн 6300 ширхэг стандартын баримт бичгийг актаар хүлээлгэн өгч стандартын хэрэгжилтийг хангуулах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

Хоёрдугаар үе шат: Газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараагийн 83 сэдвийн хүрээнд стандарт, норм дүрмийн судалгаа хийх, хотын стандартын баримт бичгийг боловсруулах ажлын даалгаврыг салбарын чиглэл, онцлогоос нь шалтгаалан 35 ангилан бүлэглэж мэргэжлийн зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –аар зарлан тухайн чиглэл бүрээр мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран ажиллах саналыг хүлээн авч шаардлага нийцсэн зөвлөхүүдтэй гэрээ байгуулах хамтран ажилласан.



Зураг 3.2. Хотын стандартын баримт бичгийн гадна харагдах байдал

Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг боловсруулах ажлын явц /2020.12.25-ны өдрийн байдлаар/

Д/д	Стандартын баримт бичгийн ажлын явц	Тоо	Тайлбар
1	Нийслэлийн хэмжээнд мөрдүүлж эхэлсэн.	14	НЗД-ын 2020 оны “Хотын стандартын баримт бичгийг мөрдүүлэх тухай” А/456 дугаар захирамжаар батлагдсан.

2	Баримт бичгийг боловсруулж дууссан.	37	Холбогдох мэргэжлийн байгууллагуудад танилцуулж холбогдох саналуудыг нэгтгэсэн.
3	Баримт бичгийн төслийг хянаж байгаа	40	Баримт бичгийг тухайн чиглэлээр мэргэшсэн зөвлөх үйлчилгээний байгууллагуудыг тендер шалгаруулалтаар сонгож гэрээ байгуулсан. Хотын стандартын баримт бичгийн төслийг хянах ажил хийгдэж байна.
4	Хүлээгдэж байгаа	6	Уг баримт бичгүүдийг боловсруулах ажлын даалгаварыг 2020.05.25-нд газрын даргаар батлуулж зөвлөх үйлчилгээний тендерийг удаа дараа зарласан боловч амжилтгүй болсноор уг ажлыг 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.
	Нийт	97	Гүйцэтгэл -91,5%

3.3 Стандартын хэрэгжилтийг хангуулах, мөрдүүлэх

3.3.1 Хот төлөвлөлт, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, газар ашиглалт, барилгажилтын бүсчлэлийг мөрдүүлэх:

2020 оны хагас жилийн байдлаар Газар барилгажилтын мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэрлэх асуудалд хот төлөвлөлт, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, газар ашиглалт, барилгажилтын бүсчлэлийг мөрдүүлэх стандарт, нормын шаардлагыг тавьж 24 удаагийн хуралд суув. Нийт 2301 асуудал хэлэлцсэний 624 барилга байгууламж, 1677 нь газрын асуудал байна. Үүнээс барилгын 378, газрын 949 асуудал шийдвэрлэгдсэн байна.

3.3.2 Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх тохижилт, бүтээн байгуулалтын ажилд стандарт мөрдүүлэх

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын баримт бичгийг 304 тендерийн баримт бичигт давхардсан тоогоор 542 удаа тусган стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2020 онд улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хот тохижилт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд стандарт, норм, дүрмийг хангуулах, мөрдүүлэх зорилгоор энэ онд хийгдэх тохижилт бүтээн байгуулалтын ажлын судалгаа, мэдээллийг нэгтгэсэн (Хүснэгт 3.1, 3.2). Нийслэлийн нутаг дэвсгэрт нийт 635 тохижилт бүтээн байгуулалтын ажил хийгдэх бөгөөд газар дээрээ ажил нь эхэлсэн 42 байршилд стандартын шаардлагыг хангуулахаар шаардлага тавьж ажиллалаа.

Газрын даргын А/10 тушаалаар “Нэг хот-нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд улс, нийслэл, дүүргийн төсвөөр хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажилд стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж ажиллах ажлын удирдамж болон ажлын хэсгийн хуваарь батлагдаж газрын албан хаагчид 9 дүүрэгт орчны аюулгүй байдлыг хангуулах, стандартуудыг дагаж мөрдүүлэхээр ажиллаж байна.

Хүснэгт 3.1. 2020 онд хийгдэх бүтээн байгуулалт, тохижилтын ажлын тоон судалгааны дүн

№	Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын баримт бичиг	Ажлын төрөл	Байршлын тоо
1		Гадна талбайн тохижилт	65
2		Гудамжны тохижилт	12
3		Тохижилт, ногоон байгууламж	23
4		Явган хүний зам	46

5	Тоглоомын талбайн тохижилт	42
6	Нийтийн тээврийн автобусны буудлын тохижилт	21
7	Тээврийн хэрэгслийн ил зогсоолын тохижилт	21
8	Такси зогсоолын тохижилт	3
9	Хашаа, хайс, хашлага	4
10	Сандал	4
11	Хогны сав	4
12	Гэрэлтүүлэг	131
13	Спорт талбай	10
14	Сургуулийн гадна тохижилт	3
15	Цэцэрлэгийн гадна тохижилт	6
16	Сүүдрэвч	1
17	Шороон зам хусаж, тэгшлэх	6
18	Явган хүний гүүр, шат	11
19	Үерийн далангийн засвар	4
20	Усан оргилуур	1
21	Барилга, барилга засвар	76
22	Автозам	31
23	Камержуулалт	41
	Нийт	635

Хүснэгт 3.2. Стандартын хэрэгжилтэд хяналт тавьсан төсөл, арга хэмжээний тоон мэдээлэл

№	Төсөл арга хэмжээний ангилал	Үзлэг, шалгалт хийсэн байршлын тоо	Стандартын шаардлага хангаагүй, зөрчилтэй	Мэдэгдэл хуудас өгсөн
1	Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага	20	14	13
2	Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага	8	3	2
3	Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ	2	0	0
4	Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах шаардлага	11	4	3
5	Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх байгуулахад тавигдах шаардлага	1	0	0
	Нийт	42	21	18

3.3.3 Барилгын гадна орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах чиглэлээр:

Нийслэлийн хэмжээнд баригдаж буй барилгын орчны аюулгүй байдлыг хангуулахтай холбоотой дараах арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Газрын даргын 2020 оны А/10, А/31 дүгээр тушаалаар батлагдсан удирдамж, хуваарийн дагуу дээрх 379 барилгаас 362 буюу 95,5%-д нь барилгын

гадна орчны аюулгүй байдлыг хангуулахаар газар дээр нь хяналт, шалгалтыг зохион байгуулан ажиллаж "Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн орчны аюулгүй байдлыг хангахад тавигдах ерөнхий шаардлага" баримт бичгийг гүйцэтгэгч байгууллагад танилцуулж мөрдөж ажиллах талаар дахин шаардлага хүргүүлсэн.

Барилгын орчны аюулгүй байдлыг хангуулах, олон жил ашиглаагүй стандарт, шаардлагад нийцээгүй хашаа бүхий хашааг стандартад нийцүүлэх ажлыг УБЗАА, НМХГ, НГЗБА, ХБХГ, ХСОАБХЗГ-тай хамтран хийж гүйцэтгэв.

Тус ажлын хүрээнд 2020.05.15-2020.06.30-ны өдөр хүртэл дүүрэг бүрд дээрх байгууллагуудын төлөөлөл бүхий ажлын хэсгүүд ажиллаж нийслэлийн хэмжээнд стандартын шаардлага хангаагүй 456 барилга угсралтын талбайн түр хашаанаас 313 хашааг шинэчлэн, 56 хашаа, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн орц гарцыг чөлөөлж 76 гаражийг тус тус албадан буулгаж энэхүү ажлын үр дүнг НЗД-ын зөвлөлийн 13,14,15-р хуралд тухай бүр танилцуулж үүрэг чиглэл аван ажиллав.

Эзэмшил газраа зориулалтын дагуу ашиглаагүй, овоолсон шороотой, ухсан нүхтэй, хог хаягдалтай байлгаж орчны бохирдол үүсгэн зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын эзэмшил газрын эрхийг цуцалж нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, явган хүний зам болгон тохижуулах 20 байршлын судалгааг гарган Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Хот байгуулалт хөгжлийн газруудад хүргүүлсэн.

Орчны аюултай байдал үүсгэсэн, стандартыг дагаж мөрдөөгүй, удаа дараагийн шаардлагыг биелүүлээгүй барилгын үйл ажиллагааг зогсоох, эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохгүй иргэн, аж ахуйн нэгжийн судалгаа хийж 95 байршлын мэдээллийг НГЗБА, ХБХГ-т орчны аюулгүй байдлыг хангуулахаар хүргүүлээд байна.

3.3.4 Гадна хаяг, зар сурталчилгааны байгууламжийн судалгаа

Төрийн байгууллагын гадна хаягийн стандарт мөрдүүлэх чиглэлээр:


Төрийн байгууллагын гадна хаягийн загвар НЗД-ын 2019 оны "Гадна хаягийн загвар батлах тухай" А/897 дугаар захирамжаар батлагдаж байгууллагууд гадна хаягаа стандартын дагуу шинэчлэх ажил зохион байгуулагдаж эхэлсэн. 2020 оны 06 сарын 27-ны байдлаар гадна хаягаа бүрэн шинэчилж байршуулсан нутгийн захиргааны 691 байгууллага байна. гүйцэтгэлийн хэрэгжилт 84.3 хувь байна.

Хүснэгт 3.3. Төрийн байгууллагын гадна хаягийн шинэчлэлт

№	Дүүрэг	ЗДТ, ИТХ	Харьяа газар, алба тасаг	Дүүргийн ӨУГ	Хороод	Эмнэлэг, /өрх/	Цэцэрлэг	Сургууль	Хаяг шинэчилсэн газар	Нийт	Хэрэгжилт %
1	Чингэлтэй	2	24	1	19	18	32	16	101	112	90.1%
2	Хан-Уул	2	23	4	21	20	29	18	73	117	62.3%
3	Баянзүрх	2	28	2	28	29	44	29	-	-	-
4	Налайх	2	22	2	8	8	7	7	40	56	71.4%
5	Сонгино хайрхан	2	24	4	43	35	52	20	180	180	100%
6	Сүхбаатар	2	21	2	20	20	33	20	150	150	100.0%
7	Баянгол	2	22	4	25	24	36	20	-	-	-
8	Багануур	2	20	5	5	5	9	3	15	49	30.6%
9	Багахангай	2	16	2	2	1	2	2	24	27	88.8%
Нийт									583	691	84.3%

Гадна зар сурталчилгааны байгууламжийн судалгаа

Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд 2020.04.02-оос 04.14-ны хооронд барилга байгууламжийн дээвэр, ханан дээр байрлах зар сурталчилгааны самбарыг нэгдсэн стандартад оруулах санал боловсруулах үүрэгтэй уг ажлын хэсэг хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлж байгаа, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг алдагдуулж буй байгууламжийг цэгцлэх, нэг загварт оруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд 1104 байршилд судалгаа хийснээс шаардлага хангасан 865ш, өнгө үзэмжгүй шаардлага хангаагүй 239ш самбар байна. Тус газраас гадна хаяг, зар сурталчилгааны стандартын загвар төслийг боловсруулж, хот байгуулалтын дундын мэдээллийн санд тэмдэглэн баяжуулан ажиллав.



Зураг 3.4. Гадна зар сурталчилгааны байгууламжийн судалгааны байршил, загвар зураг



График 3.4. Зар сурталчилгааны самбарын төрөл




3.4 Орчны аюулгүй байдлын мэдээлэл, зөрчлийг бүртгэх


Орчны аюулгүй байдлын мэдээлэл, бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэв

1. Газрын даргын 2020 оны А/10 дугаар тушаалын дагуу байгуулагдсан ажлын хэсгийн “Барилга замын ажил гүйцэтгэхэд тавигдах ерөнхий шаардлага”-ын талаар мэдээлэл өгч, биечлэн хүргэж ажилласан нийслэлийн 6 дүүргийн 174 байршлын мэдээллийг газарзүйн мэдээллийн системийн ArcGIS программд нэгтгэн байршил бүрийн гүйцэтгэгч, захиалагч, барилгын зориулалт, барилгын зөвшөөрөл, холбоо барих мэдээллээр байгууллагын цахим мэдээллийн санг баяжуулж, Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулах зурган мэдээллийг боловсруулсан. Нийт 9 дүүргийн ажлын хэсгийн арга хэмжээ авч ажилласан 311 барилгын гадна түр хашааны мэдээллийг нэгтгэн, орчны аюулгүй байдлын мэдээллийн санг баяжуулж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллав.
2. Нийслэлийн нутаг дэвсгэрт газрын зөрчил арилгах, газар чөлөөлөх арга хэмжээ авах байршлуудыг орчны аюулгүй байдлын мэдээллийн санд тэмдэглэн оруулах НГЗБА-наас ирүүлсэн мэдээллийг үндэслэн орчны аюулгүй байдлын мэдээллийн санг чөлөөлөхөөр төлөвлөгдөж буй нийт 7 дүүргийн 164 байршлын мэдээллээр баяжуулсан.
3. “Нийслэлийн иргэдийн амьдрах орчны газрын зураглал, мэдээллийн нэгдсэн систем” /www.manaikhoroo.mn/ дээр бүртгэгдсэн зөрчлийн мэдээллийн тоон үзүүлэлтийг ангилж, шийдвэрлэлтийн явцад 2020 оны 03 дугаар сарын 25, 27, 30-ны өдрийн байдлаар дүн шинжилгээ, харьцуулалт хийсэн.
4. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/556 дугаар захирамжийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа явуулж буй "зөрчилтэй барилгын хашаа" судалгааны 285 ш байршлыг нэгтгэж, газар зүйн мэдээллийн системийн shp файлаар www.manaikhoroo.mn веб сайтад байршуулахаар Нийслэлийн Мэдээлэл, технологийн газарт хүлээлгэн өгсөн.
5. Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас ирүүлсэн орц, гарцыг чөлөөлөхөөр төлөвлөгдөж буй нийт 7 дүүргийн 164 байршлын мэдээллийг орчны аюулгүй байдлын мэдээллийн санд бүртгэж, газар зүйн мэдээллийн сангийн зураглал бэлтгэв.
6. 2020 онд хэрэгжих тохижилт, бүтээн байгуулалтын 9 дүүргийн 570 ажлын байршил, мэдээллийг цуглуулж, нэгдсэн загварын дагуу боловсруулж, Хотын стандартын мэдээллийн санг баяжуулсан. Нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд 7 төрлийн сэдэвчилсэн зураглал, тоон мэдээг бэлдэж, газрын даргад хүлээлгэн өгсөн.
7. Нийслэлийн 9 дүүргийн 311 зөрчилтэй барилгын хашааны мэдээллийг нэгдсэн загварын дагуу нэгтгэн, орчны аюулгүй байдлын мэдээллийн санг баяжуулж, сэдэвчилсэн зураг бэлтгэв.
8. Улаанбаатар хотын гудамжны нэр, хаяг, чиглэлийн тэмдгийн ерөнхий шаардлага боловсруулах судалгааны ажилд шаардлагатай уулзвар, гарцын

байршлын 32 төрлийн зургийг бэлтгэн Бодлого төлөвлөлтийн хэлтэст хүлээлгэн өгсөн.



Зураг 3.5. Шаардлага хүргүүлэх ажлын явцын зураг



Зураг 3.6. Албадан чөлөөлсөн хашааны байршлын зураг

3.5 Хотын стандарт, техник зохицуулалтын баримт бичгийн тогтолцоог бий болгох

Эрхзүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

Стандартчилал, техникийн зохицуулалтын эрх зүйн үндэс, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд уг хуулиар хотын стандарт тогтоох эрхийг хуулиар тусгайлан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргад олгоогүй, хотын стандарт гэсэн стандартчиллын баримт бичиг байх, талаар тусгаагүй байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хот, тосгон, нийслэлийн удирдлага хотын захирагчийн бүрэн эрх хэсэг дэх заалтад хотын стандарт, норм, дүрмийг боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих чиглэлээр өөрчлөлт оруулах саналыг боловсруулан 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 02/27 дугаар албан бичгээр хүргүүлээд байна.

Стандартын хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд:

Стандарт хэмжил зүйн газартай байгуулах санамж бичгийн төсөл боловсруулж 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр санал авахаар албан бичгээр тус газарт хүргүүлээд байна. Санамж бичгийн зорилго нь Нийслэлийн иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд чанарын дэд бүтцийг бий болгох, стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах, тохирлын үнэлгээний үйл ажиллагааг хөгжүүлэх, байгууллага болон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх,

төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, иргэдийн чанар стандартын талаар мэдлэг чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанд харилцан туслалцахад оршино.

Санамж бичигт хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Үндэсний стандартын мэдээллийн салбар санг Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлаг Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газарт ажиллуулах;
- Стандарт, техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх арга зүйн талаар төрийн албан хаагч нарын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх талаар сургалт явуулах, судалгаа хийх, туршлага судлах, солилцох үйл ажиллагааг хамтран зохион байгуулах;
- Чанар стандартын талаар иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах;
- Стандарт, техникийн зохицуулалт боловсруулах, батлах, хэрэгжүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, техникийн туслалцаа үзүүлэх;
- Олон улсын стандартын байгууллагын “Smart City” стандартын салбар техникийн хороо болон Монгол улсын үндэсний стандартын техникийн хороодод Нийслэлийн мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах;
- Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;

Нийслэлийн иргэдэд хүргэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийх итгэмжлэлийн тогтолцоог хөгжүүлэх багтана

Стандартын баримт бичгийн төсөлд санал тусгах чиглэлээр:

Монгол улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газраас 05/394, 05/392, 05/395 дугаар албан бичгээр ирүүлсэн шинээр боловсруулсан болон дахин хянасан 18 ширхэг стандартын төслийг судалж холбогдох саналыг тусгаж албан бичгээр хариу хүргүүлэв. Санал хүргүүлсэн үндэсний стандартууд:

1. MNS 5160, “Үс засах үйлчилгээ” дахин хянасан
2. MNS 5567, “Гоёлын гоо заслын үйлчилгээнд тавих шаардлага” дахин хянасан
3. “Хумс заслын үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” шинээр боловсруулсан
4. MNS 899:2020, “Унд ахуйн зориулалттай төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг сонгох журам ба эрүүл ахуй, техникийн шаардлага”
5. “Оршуулгад хамаарах үйлчилгээ. Тавих ерөнхий шаардлага”
6. “Маанийн дунд оврын хүрд. Техникийн ерөнхий шаардлага”
7. MNS 5283, “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих шаардлага” шинэчилсэн стандарт
8. “Ган татлагын аюулгүй ажиллагаа”-нд тавигдах шаардлага бүхий стандарт /12 бүлэг/
9. “Мэдээлэл харилцаа холбооны техникийн өрөөнд тавигдах шаардлага”

10. “MNS 5594:2015 Радио давтамжтай цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин (3 кГц-ээс 300 ГГц хүртэл)”
11. “MNS 5596:2006 Цахилгаан холбооны сүлжээнд ажиллахад тавих аюулгүй ажиллагааны шаардлага”

Худалдан авах ажиллагааны эрх шилжүүлсэнтэй холбогдуулан хэрэгжүүлсэн арга хэмжээ

Нийслэлийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд санхүүжилт хийгдэх эрх шилжүүлсэнтэй холбогдуулан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 60 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд тендерийн баримт бичиг болон гэрээний нөхцөлд зайлшгүй тусгавал зохих барилгын норм дүрэм, нийслэлээс шинээр батлан мөрдүүлсэн стандарт, дүрэм журам, хэм хэмжээний акт, тавигдах шаардлагыг тодорхой болгон мөрдүүлэх үүргийн дагуу Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн мэдээлэл авах тухай 01/265 дугаар тоот албан бичгийг ирүүлсэн. Тус албан бичгийн хүрээнд 60 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээний нөхцөлд зайлшгүй тусгавал зохих барилгын норм дүрэм, стандартын тавих шаардлагуудыг арга хэмжээ тус бүрээр боловсруулан 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр 02/36 дугаар тоот албан бичгээр хариуг хүргүүлэв.

Стандартын техникийн хороонд ажилласан байдал

Стандарт хэмжил зүйн газрын стандартын техникийн хороонд тус газрын албан хаагчид орж ажилладаг бөгөөд дараах стандартын төсөлд санал өгч ажиллав. Үүнд:

1. “Маанийн дунд оврын хүрд. Техникийн ерөнхий шаардлага”
2. MNS 5160, “Үс засах үйлчилгээ” дахин хянасан
3. “Оршуулгад хамаарах үйлчилгээ.

Хурлаар дээрх стандартын төслүүд дэмжигдсэн бөгөөд хэл найруулгын болон бусад холбогдох засваруудыг хийн, эцсийн байдлаар төслүүдийг техникийн хороодын гишүүдэд цахим шуудангаар илгээн танилцуулахаар болсон байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын стандартын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/22 дугаар тушаалаар Стандартын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажлын хэсгийн гишүүнээр хамтран ажиллаж байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын байранд 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр ажлын хэсэг хуралдсан бөгөөд хуралдаанаар стандартын баримт бичгийн агуулга, товхимлын бүтэц, боловсруулалтын аргачлал зэрэг арга зүйн зөвлөгөө өгөн ажиллав.

3.6 Хотын стандартын талаар зөвлөгөөн, сургалт зохион байгуулж холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэлээр:

Монгол улсын үндэсний стандарт, Барилгын норм ба дүрмийн стандартын сан бүрдүүлж албан хэрэгцээнд ашиглах хэрэгцээ шаардлага гарч 2020 оны 04

дүгээр сарын 20-ны өдөр А/27 дугаар тушаалаар 1,504,490 төгрөгийн үнийн дүнтэй Үндэсний болон Олон улсын стандарт-36-г Стандарт хэмжил зүйн газраас, Барилгын хөгжлийн төвөөс барилгын норм ба дүрэм 69 ширхэгийг тус тус худалдан авсан. Газрын үйл ажиллагааны оновчтой хуваарилалт, үр ашигтай ашиглах хүрээнд баримт бичгийг зориулалтын газарт хадгалж, бүртгэл хөтлөн ажиллах зорилгоор Архивын ажилтанд хүлээлгэн өгч тэмдэглэл хөтлөн өдөр тутам ашиглаж байна.



Зураг 3.8. Үндэсний стандарт /MNS/, Барилгын норм ба дүрэм /БНБД/

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад хийсэн сургалт

Нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын ажлыг эрчимжүүлэх, стандартын баримт бичгийн талаар цогц ойлголт, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор 4 удаа сургалт зохион байгуулсан. Үүнд:

Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газраас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн

№	Сургалтын агуулга	Хугацаа	Оролцогчид	Тоон үзүүлэлт /албан хаагчийн тоо/
1	Хотын стандартын баримт бичгийн тухай	2020.04.27-2020.05.01	Нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-ын удирдах албан хаагчид	107
2	Хотын стандартын баримт бичгийн тогтолцоо, Чанарын удирдлагын тогтолцоо, “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн төлөвлөгөөний тайлан гаргах	2020.05.12-2020.05.13	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын удирдах албан хаагчид	85
3	Хотын стандарт, чанарын удирдлага, зорилтот төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах талаар	2020.09.03-2020.09.21	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газруудын захиргааны хэлтсийн дарга, албан хаагчид	258
4	“Хууль, эрх зүй”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Стандарт, чанарын удирдлага” сэдэвт сургалт	2020.10.01-2020.11.01	Нийслэлийн харьяа газруудын шинэ, залуу албан хаагчид	304

- Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын удирдах түвшний 107 албан хаагчдад 04 -р сарын 27-оос 05-р сарын 01-ны өдрүүдэд
- Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа 31 байгууллагын 85 хэлтсийн дарга, удирдах албан хаагчдад 2020 оны 05 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан.

Сургалтаар хотын стандартын баримт бичгийг нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх, улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй хот тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг үр ашигтай, чанартай гүйцэтгүүлэх зорилгоор Хотын стандартын баримт бичгийн тогтолцоо, стандартын талаарх танилцуулга сургалтыг 5 бүлэг сэдвийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Удирдлагын академи, Хот байгуулалт хөгжлийн газартай хамтран зохион байгуулан ажилласан. Сургалтад нийт 192 албан тушаалтан хамрагдсан.



Зураг 3.7. Үйлдвэрлэл инноваци, сургалтын төв

3.7 Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн “Төрийн байгууллагад ажлын байрны шинжилгээ хийх удирдамж”-ийн хүрээнд мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх, тайлагнах гэсэн дарааллаар нийт 60 ажлын байрны тодорхойлолтын мэдээлэл цуглуулан байгууллагын хэмжээнд анх удаа ажлын байрны шинжилгээг зохион байгуулан тайлан мэдээг 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.

Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр батлуулсан. Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөнд 29 ажил, үйлчилгээ тусгагдсанаас 5 ажил нь хөрөнгө шийдвэрлүүлэх шаардлагатай, 24 ажлын гүйцэтгэлийн биелэлт 2020 оны хагас жилийн байдлаар 50 хувийн хэрэгжилттэй, жилийн эцсийн байдлаар 88 хувиар хэрэгжсэн байна.

Байгууллагын хүний нөөцийн бүртгэлийг “Нутгийн захиргааны байгууллагын хүний нөөцийн удирдлагын ERP систем”, “Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн систем”-д тус тус бүртгэн оруулж тогтмол шинэчлэн баяжуулан баталгаажуулан ажилласан. Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд шаардлагатай мэдээ мэдээллийг уг системээс гарган авч өдөр тутмын үйл ажиллагааг цахимжуулан ажиллаж байна. Дээрх системд төрийн албан хаагчийн шилжилт хөдөлгөөний тайлан мэдээг

тухай бүрт тогтмол шивж тайлагнасан. 2020 оны хагас жилийн байдлаар 7 албан хаагч ажлаас чөлөөлөгдөж, шинээр 9 албан хаагч томилогдож, албан тушаал дэвшиж сэлгэн ажилласан 5 албан хаагч байна. Газрын хэмжээнд нийт 29 албан хаагч ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байдал:

Удирдлагын академийн ахлах түшмэл, богино дунд хугацаа, чиглүүлэх сургалтад газрын 16 албан хаагчийг бүртгүүлж хамруулсан. Үүнд:

- Ахлах түшмэлийн багц сургалтад 2 албан хаагчийг 2020.05.01-05.30-ны өдрүүдэд хамруулж сертификатаа авсан.
- Төрийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны сургалтад газрын нийт 5 албан хаагч
- Хүний нөөцийн мэргэшүүлэх сургалтад Захиргааны хэлтсийн мэргэжилтэн 2020.06.01-2020.06.30-ны хооронд хамрагдсан.
- 2020 оны 06 дугаар сард Удирдлагын академийн төрийн албаны “Богино, дунд хугацааны мэргэшүүлэх багц сургалт”-д Захиргааны хэлтсийн 2 албан хаагч
- 2020 оны 06,09 дүгээр саруудад Удирдлагын академийн “Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдад зориулагдсан чиглүүлэх 40 цагийн багц сургалт”-д 6 албан хаагч.

Гадаад сургалт

Оросын Холбооны Улсын нийслэл Москва хотын холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэх зорилготой Нийслэлийн Зам тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Отгонсүхээр ахлуулсан удирдлага, холбогдох байгууллагуудын дарга, асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс бүрдсэн нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй баг 2020 оны 1 дүгээр сарын 20-ноос 24-ний өдрүүдэд албан томилолтоор ажилласан.

Москва хотын Авто замын техникийн Улсын их сургууль МАДГТУ (МАДИ), Олон улсын авто машины болон замын боловсролын холбооны (МААДО), Замын барилгын материалын тэнхим, Замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдлын тэнхим, Замын хөдөлгөөнийг удирдах газар “ЦОДД”, Москвагийн авто тээврийн зогсоолын захиргаа “МосПаркинг”, Нийтийн тээврийн үйлчилгээ явуулдаг “Мосгортранс” зэрэг байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж Улаанбаатар хотын авто замаар зорчиж буй авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах, замын ачаалал, тээврийн хэрэгслийн зөрчлийн мэдээллийг хянах, төлбөртэй зогсоол болон авто замын төлбөр хураалт, түүний хяналтын үйл ажиллагааг автоматжуулах зорилго бүхий “Авто замын хөдөлгөөн зохицуулалт, төлөвлөлтийн систем”-ийг хөгжүүлэн, нэвтрүүлэхэд зорилготой дээрх газруудын үйл ажиллагааг судалж туршлага солилцсон. Албан томилолтын хүрээнд Улаанбаатар хотыг төлөөлж Нийслэлийн Засаг даргын орлогч бөгөөд Зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б. Отгонсүх, Москва хотын Авто замын техникийн Улсын их сургуулийг төлөөлж тус сургуулийн захирлын үүрэг түр гүйцэтгэгч Зиманов Л.Л. нар хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурсан. 2020 оны 02 дугаар сарын зөвлөлийн хуралд гадаад томилолтын ажлын үр дүнг танилцуулсан.

Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар:

Газрын албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулахаар 7 хоног бүрийн Мэдээллийн цагийн сургалт болон газрын хурлаар тогтмол албан хаагчдад мэдээлэл хүргэж ёс зүйн дотоод дүрмийн хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Ёс зүй сахилга хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж хэрэгжүүлэв. Үүнд:

- 2020.02.07-ны өдөр Газрын даргын “Ёс зүйн зөвлөл байгуулж, журам батлах тухай” А/07 дугаар тушаалаар байгууллагын ёс зүйн дүрмийг шинэчлэн батлав.
- 2020 оны эхний хагас жилийн байдлаар газрын “Ёс зүйн зөвлөл”-ийн хурал 5 удаа хуралдуулан тухай бүр хурлын тэмдэглэл хөтлөн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллав.

3.9. Архив, албан хэрэг хөтлөлт болон албан бичиг, өргөдөл, гомдол шийдвэрлэлт:

2020 онд тус газарт нийт 1735 аж ахуйн нэгжээс албан бичиг, иргэдээс 213 өргөдөл, гомдол ирж, бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэд рүү нийт 613 албан бичиг явуулсан байна.

Албан бичгийн мэдээ /2020.01.01-2020.12.31/


Ангилал	Нийт	Шийдвэрлэлт		Шийдвэрлэлт хувь	Үүссэн зөрчил
		Хугацаанд нь	Хугацаа хэтэрсэн		
Ирсэн албан бичиг	1735	1705	30	98,97	42
Иргэний өргөдөл, гомдол, хүсэлт	213	206	7	99,53	94
Явсан бичиг	613				
Нийт	2135				

Иргэний өргөдөл, гомдолд үүссэн 140 зөрчил нь шийдвэрлэлтийн асуудалд үүссэн бус явцын тэмдэглэл бичээгүй болон өдөрт нь шилжүүлээгүй гэх хэлбэрээр үүссэн байна.


\Графикаар харуулав\



Хоёр: Иргэний ирүүлсэн хүсэлтүүдийг ангилан харуулав.





2019-2020 онуудад иргэдээс ирүүлсэн асуудлын харьцуулсан үзүүлэлт:



Архивын ажлын талаар:

Тус газрын архив нь 2019 онд 4 хэлтэстэйгээр үндсэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. 2020 онд 67 хадгаламжийн нэгж бүрдүүлж өөрийн гэсэн сан хөмрөгтэй болсон. Хагас жилийн байдлаар Архивын сан хөмрөгийг Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо /Монгол Улсын барилгын норм ба дүрэм/ 96 стандартын баримт бичгээр нөхөн бүрдүүлэлт хийсэн



Зураг 3.9. Архивын үзлэг

Архивын баримтыг байнга, түр, 70 жил хадгалах 3 данс үүсэх, сан хөмрөг үүсгэсэн. архивын баримтад Баримт бичгийн нягтлан шалгалт хийгдсэн, сэлбэн засах, сэргээн шинэтгэх, эмхлэн цэгцлэхэд шаардлагатай баримт бичгүүдэд эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийгдэж байгаа.

2019 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, архив бүрдүүлсэн хадгаламжийн 51 нэгжид үзлэг хийж дахин засварлах баримтууд байгааг олж илрүүлэн шаардлагатай засварыг хийв.

Архивын баримт ашиглалт:

2019 оны 15 хадгаламжийн нэгжээс албан хаагчдын судалгаа, шинжилгээнд ажлын байранд 1500 хуудас ашиглуулсан. Төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалтад орох албан хаагчдын материалын 229 хуудас хуулбарлан “Хуулбар үнэн” тэмдгээр 116 хуудас баталгаажуулсан байна.




График 3.9. Архивын ажил үйлчилгээ

3.10 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус газраас зохион байгуулж байгаа худалдан авах ажиллагааны явц, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны (www.tender.gov.mn)-ийн цахим системд баталгаажуулан хяналт тавьж дараах ажлыг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

- Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Төсвийн задаргаа батлах тухай” А/199 дүгээр захирамжийн дагуу Газрын 2020 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг 5 бүлэг 164 заалттайгаар газрын даргаар батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны (www.tender.gov.mn) цахим системд төлөвлөгөөг Сангийн яамаар баталгаажуулав.
- Газрын хэмжээнд 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нээлттэй болон Зөвлөх үйлчилгээний тендерийн эрхийг үүсгэн баталгаажуулан хяналт тавьж ажиллав.

2020 оны хагас жилийн байдлаар газрын бараа, ажил үйлчилгээ худалдан авах төрийн худалдан авах ажиллагааны (www.tender.gov.mn)-ийн цахим системээр зарлагдсан тендер шалгаруулалтыг үзүүлбэл:

➤ Төлөвлөсөн тендер	124
➤ Зарласан тендер	46
➤ Цахим тендер шалгаруулалт	50
➤ Үр дүн нийтэлсэн тендер	40
➤ Зөвлөх үйлчилгээ болон шууд худалдан авалт	82
➤ Үр дүн нийтэлсэн шууд худалдан авалт	38



Зураг 3.10. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем

3.11 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаа:

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1000 дугаар захирамжаар тус газрын бүтэц, орон тоонд өөрчлөлт орж газрын дүрмийн 3.1.10-д “Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулах” гэсэн чиг үүрэг нэмэгдсэн. Тус чиг үүрэг нь Хот байгуулалт, хөгжлийн газарт хэрэгжиж байсан тул холбогдох албан хаагчдыг Төрийн албаны тухай хуулийн 44.1 дэх заалтын дагуу шилжүүлэн томилж тус чиг үүргийг жигд тасралтгүй мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэн ажилласан. Дээрх бүтэц, чиг үүргийн өөрчлөлттэй холбоотой

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1022 дугаар захирамжаар “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг байгуулж тус газрын дарга комиссын даргаар ажиллаж эхэлсэн.

Газрын даргын 2020 оны А/63 дугаар тушаалаар засвар, шинэчлэл их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг тус тус батлан 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах тухай хүсэлтийг 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ERP цахим системээр хүлээн авч шийдвэрлэдэг

байсан бол улс даяар хэрэгжиж буй **e-mongolia** цахим системээр хүлээн авч судлах ажлыг эхлүүлсэн.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуваарийг Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалтын асуудал хариуцсан төслүүдийн удирдагчаар, их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын хуваарийг газрын даргаар тус тус батлуулж долоо хоног бүрийн Пүрэв гарагт газрын вэб хуудсанд мэдээлж ажилласан. Хуваарийн дагуу комисс ажиллаж баталгаажуулсан актын дагуу хот байгуулалтын орон зайн мэдээллийн санд баяжилт хийж тухайн барилга байгууламжийн холбогдох мэдээллийг оруулсан байна. 2020 онд нийт 782 барилга, байгууламжийн мэдээллийг баяжилт хийсэн байна.

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ТӨСЛҮҮДИЙН УДИРДАГЧ О.МӨНГӨНШАГАЙ
2020 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУВААРЬ

/2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 16-ны өдөр/

№	Байршил	Нэр төрөл, хүчин чадал	Захиалагч	Гариг	Ажиллах он, сар, өдөр, цаг
1	Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо	Үйлчилгээтэй 22 айлын орон сууцны барилга	Мотиваци ХХК	Даваа	2020.10.12 10 ⁰⁰ цагт
2	Баянгол дүүрэг 20 дугаар хороо	Агуулах	Цац барилга ХХК	Даваа	2020.10.12 12 ⁰⁰ цагт
3	Баянзүрх дүүрэг 13 дугаар хороо	Албан контор	Шинжлэх ухааны академийн хүрээлэн	Даваа	2020.10.12 14 ⁰⁰ цагт
4	Баянзүрх дүүрэг 25 дугаар хороо	Үйлчилгээтэй 98 айлын орон сууцны барилга	Хүрд ХК	Даваа	2020.10.12 16 ⁰⁰ цагт
5	Баянгол дүүрэг 16 дугаар хороо	Ариутгах татуургын шугамын ажил	нийслэлийн Хэрэгвэ оруулалтын газар	Мягмар	2020.10.13 10 ⁰⁰ цагт
6	Сонгинохайрхан дүүрэг 25 дугаар хороо	151 дүгээр сургуулийн халаалтын зуух	Барилгын хөгжлийн төв	Мягмар	2020.10.13 12 ⁰⁰ цагт
7	Сүхбаатар дүүрэг 13, 14 дүгээр хороо	Сэлбэ дэд төвийн иргэдийн сэлбэ	Нэвсэн ХХК	Мягмар	2020.10.13 14 ⁰⁰ цагт

ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ХОТ


НҮҮР БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ МЭДЭЭ ШИЛЭН ДАНС ИЛ ТОД БАЙДАЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХОЛБОО БАРИХ

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуваарь


2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2020 оны 4 дүгээр сар

Зураг 5 Комиссын ажлын хуваарийн газрын вэб хуудсанд мэдээлсэн байдал



Зураг 5 Орон зайн мэдээллийн сангийн зураг



Зураг 6 Орон зайн мэдээллийн санд мэдээлэл оруулах өгөгдөл

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг үйл ажиллагааг Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газарт шилжүүлснээс хойш буюу 2020.08.05-2020.12.25-ны хооронд 1089 иргэн, ААН-ийн хүсэлтийг хүлээн авснаас 478 барилга байгууламж, их засвар, шинэчлэлт, тохижилтын ажлын стандарт, норм дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, байнгын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж, 510 барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг баталгаажуулаад байна. Одоогоор 101 хүсэлтийг судалж байна



Монгол Улсын Засгийн газрын 178,181 дүгээр тогтоолоор Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гамшгаас хамгаалах “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээр барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагаа түр зогссон.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, чухал шаардлагатай барилга, угсралт, засвар шинэчлэлтийн ажлыг бүх нийтийн хөл хорионы дэглэмийн үед ашиглалтад оруулах талаар удирдамж, заавар боловсруулан Нийслэлийн ЗАСАГ даргын Хот байгуулалтын асуудал хариуцсан төслийн удирдагч Б.Сүхбаатарт танилцуулж 2020.12.01-ний өдөр батлуулсан.

Дээрх удирдамжийн дагуу чухал шаардлагатай барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийн үед зохион байгуулан ажилласан.



Зураг. №8 Эмнэлгийн их засвар, шинэчлэлийн ажлыг улсын комисст хүлээн авах ажиллагаа

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1 Үйл ажиллагааны ил тод байдал

2020 оныг “Нэг хот-Нэг стандарт”-ын жил болгосонтой холбогдуулан зорилтод жилийн хүрээнд нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэр үр дүн ач холбогдлыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг 11 бүлэг 47 заалттайгаар боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан.

Хүснэгт 4.1. Олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэсэн байдал

№	Овог, нэр	Албан тушаал	Мэдээний төрөл			
			Мэдээ	Нэвтрүүлэг	Ярилцлага	Сурвалжилга
1	С.Төмөрдулам	Газрын дарга	3	-	6	-
2	О.Оджаргал	Орлогч дарга	6	-	2	1
3	Б.Од-Эрдэнэ	БТХ-ын дарга	-	-	3	-
4	Б.Ариунтуяа	СХХ-н дарга	3	1	1	-
5	Н.Билэгсайхан	ОАБХХ-ын дарга	2	-	-	-
6	Д.Өлзийсайхан	ОАБХХ-ын Ахлах мэргэжилтэн	4	-	-	-

“Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа ажлыг сурталчлан нийслэлийн нутгийн захиргааны 7 байгууллагын (Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Цагдаагийн газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв, Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв, Гэр бүл, хүүхэд Залуучуудын хөгжлийн газар) үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан олон нийтэд мэдээ, мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулсан.



Газрын дарга С.Төмөрдулам Ийгел ТВ-ийн “Нэг сэдвээр” хэлэлцүүлэгт оролцов. /2020.04.30-ны өдөр/



Орлогч дарга О.Оджаргал Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 12 дугаар хурлын тэмдэглэлийн үүрэг даалгаврын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл өгөв. /2020.06.10-ны өдөр/



ОАБХХ-ын Ахлах мэргэжилтэн Д.Өлзийсайхан Хан-Уул дүүрэгт стандартын шаардлага хангахгүй хашааг албадан буулгах ажлын талаар мэдээлэл өгөв. 2020.06.04



Jargal de Facto нэвтрүүлгээр “Хотын стандарт” сэдвээр асуудал хөндөн ярилцав. 2020.06.18

Хотын стандартын техник зохицуулалтын баримт бичгийг иргэд, олон нийтэд танилцуулан сурталчлах хүрээнд олон нийтийн телевизээр 30, сонинд 2, мэдээллийн цахим сайтуудад 35 удаа мэдээ мэдээлэл өгч ажилласан.



2020 оны 5 дугаар сарын 21 -ны өдөр Eagle телевиз “Зочны цаг” нэвтрүүлэг



2020 оны 5 дугаар сарын 20 -ны өдөр Vtv телевиз

“Хүнд ээлтэй хот” хэлэлцүүлэгт тус газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга модератороор оролцов.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
2020.05.25 - 11:30

BARILGA
EXPO
2020

f LIVE
www.facebook.com/barilgamn/

ХҮНД ЭЭЛТЭЙ ХОТ БАЙГУУЛАЛТ

Г.БАТСУХ
Барилга.МН
Ерөнхий захирал
МОДЕРАТОР

Б.ГҮНБОЛД
БХБЯ-ны хот байгуулалт,
газрын харилцааны бодлогын
хэрэгжлийг зохицуулах
газрын дарга

М.УЯНГА
Эн Эй Пи Групп
ХХК-ийн гүйцэтгэх
захирал

Б.ОД-ЭРЭЭНЭ
Хотын стандарт, орчны аюулгүй
байдалын хяналт, зохицуулалтын
газрын бодлого төлөвлөлтийн
хэлтсийн дарга


А.ЛЭНД
Монголын барилгын
ундэсний ассоциацийн
дэд ерөнхийлөгч

Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Журам батлах тухай” А/1212 дугаар захирамжийн хүрээнд “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах журам батлагдсан. Энэ хүрээнд газрын дарга, удирдлагууд журам, хуваарийн дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай уулзаж тэмдэглэл хөтөлсөн байна.

Байгууллагын цахим хуудас, фэйсбүүк пэйж хуудсанд байгууллагын үйл ажиллагааг байршуулж ил тод, нээлттэй ажиллах хүрээнд:

Газрын вэб сайтад зохих журмын дагуу мэдээ мэдээлэл бэлтгэн нийтлэхээс гадна шилэн данс, тендертэй холбоотой мэдээллийг цаг тухай бүрд нь нийтэлж олон нийтийг мэдээллийг ил тод хүргэж байна. Үүнд:

- Байгууллагын зорилго, зорилт, танилцуулга, хэлтсүүдийн чиг үүрэг
- Тендерийн зар 30 удаагийн зөвлөх үйлчилгээний зарлал, 5 зөвлөх үйлчилгээний урилга, нээлттэй тендер шалгаруулалтын 2 зарлал tender.gov.mn цахим системд нийтэлсэн
- Сул орон тооны зар
- Газрын даргын А тушаал 42
- Шилэн дансны мэдээлэл



ХЭДЭЭ	БАЙГУУЛАГЫН ТУХАЙ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	МЭДЭЭ МЭДЭЭХЭЭЛ	СУЛ ОРОН ТОО	ИЛ ТОД БАЙДАЛ	ХОЛВОО БАРИХ	
1	A/01	Бугд орон тоо батлах тухай				2019.05.22	УЗХХ
2	A/02	Кадменийн дорлоод журам батлах тухай				2019.06.03	УЗХХ
3	A/03	Тендер түрээс, квалитет хуудсанд нэмэлт тэмдэг ажлын харилцангүй албан тушаалын төлөмөс тухай				2019.05.22	УЗХХ
4	A/04	Учиртгаар хороо байгуулах тухай				2019.06.06	УЗХХ
5	A/05	Учиртгаар хороо байгуулах тухай				2019.06.06	УЗХХ
6	A/06	Хэлтсийн өндөс батлах тухай				2019.06.07	УЗХХ
7	A/07	Арван албан хэргэ квалитетийн ажлын зохион байгуулалтын журам батлах тухай				2019.06.07	УЗХХ
8	A/08	Албан тушаалын тодорхойлогч боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай				2019.06.24	УЗХХ
9	A/09					2019.07.16	УЗХХ
10	A/10	Клиент байгуулах тухай				2019.07.16	УЗХХ
11	A/11	Клиент байгуулах тухай				2019.07.22	УЗХХ

ТӨРӨН	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
1	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○
2	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○

ТӨРӨН	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
1	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○
2	○	○	○	○	○	○	○	○	○	○	○	○

Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах: Шилэн данс:

2020 оны хагас жилийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох 5 төрлийн тоон мэдээллийг хуулийн хугацаанд shilendans.gov.mn цахим сүлжээнд байршуулсан байна. Тухайлбал цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын 118,5 сая төгрөгийн орлого, зарлагын мэдээллийг оруулсан байна. Мөн сар бүр төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан мэдээ, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт гэх зэрэг шилэн дансанд заавал оруулах мэдээллийг байршуулан оруулсан.

ТӨСӨВ / ГҮЙЦЭТГЭЛ		ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ							
№	ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ	2020 1 сар	2020 2 сар	2020 3 сар	2020 1-р улирал	2020 4 сар	2020 5 сар	2020 6 сар	2020 Хагас жил
1	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (<i>Тухай бүр</i>)	✓	✓	✓	—	✓	✓	✓	—
2	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (<i>Тухай бүр</i>)	✓	✓	✓	—	✓	✓	✓	—

4.2 Хүний нөөцийн ил тод байдал

Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 42, Сул орон орон тооны зар, Газрын бүтэц орон тооны зохион байгуулалт, Иргэн, аж ахуй нэгж, төлөөлөлтэй уулзалт хийх журмыг газрын цахим хуудсанд байршуулан ил тод нээлттэй мэдээлэн ажилласан.


ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

Шинэ коронавирүс /Covid-19/-ийн халдвараас иргэд, олон нийтийг хамгаалахтай холбоотой Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрийн хэрэгжилт:


Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/166, А/168, А/191, А/223, А/268 А/333, А/438, А/436, А/560, А/590 дүгээр захирамжууд, Нийслэлийн онцгой комиссын 1-10 хүртэлх хуралдааны шийдвэрүүд цаг үеийн шаардлагаар батлагдаж хэрэгжүүлэх ажил нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан. Эдгээр захирамж шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой тус газар нь дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:

- Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу Шинэ коронавирүсийн халдвараас иргэд, олон нийтийг урьдчилан сэргийлэх нэгдсэн хяналт тавьж ажиллах “Эргүүл”-ийн үүрэг гүйцэтгэх ажлын удирдамж, байршлын хуваарийг Нийслэлийн онцгой комисстой хамтран боловсруулж Нийслэлийн Онцгой комиссын Орлогч дарга Ж.Батбаясгалангаар батлуулсан.

- Тус газрын нийт албан хаагчид дээрх удирдамж, хуваарийн дагуу Баянзүрх дүүргийн 1-р хорооны 1,2 дугаар бүсэд 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэж дүн мэдээг Баянзүрх дүүргийн шуурхай штабт өдөр бүр тайлагнаж ажилласан.




Зураг 5.1. Нутгийн захиргааны байгууллагууд хуваарилагдсан дүүргүүдэд хяналт тавих байршлын бүсчилсэн зураг



Зураг 5.2.Эрэгүүлд гарахдаа зүүх албан хаагчдын ханцуйвчны загвар зураг/ Зураг /Эрэгүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа байдал

- Нийслэлийн Засаг даргын тамгын газрын баталсан шалган нэвтрүүлэх товчоонд ажиллах хуваарийн дагуу ОАБХХ-ийн мэргэжилтэн Г.Бат-Эрдэнэ, БТХ-ийн мэргэжилтэн У.Санчир нар Эмээлт, Ар гүнтийн шалган нэвтрүүлэх товчоонд 24 цагаар үүрэг гүйцэтгэж ажилласан.



Зураг 5.3. 24 цагийн жижүүр

Газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/86 дугаар тушаалаар “Зайнаас ажиллах түр журам” –ыг батлан нийт албан хаагчдын 30 хүртэл хувийг ажлын байранд, бусад албан хаагчдыг гэрээсээ цахимаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах арга хэмжээ авсан.

- Газрын удирдлагыг цахим хурал, зөвлөгөөнд оролцох боломжийг бүрдүүлж хурлын тоног төхөөрөмж, сүлжээний хэрэгслийг нийлүүлсэн.
- Цахим орчинд албан хаагчдын өдөр тутмын ажлыг үнэлэх, хянах зорилгоор үүлэн технологийг ашиглаж ажлын мэдээ, тайланг хянах дундын файл үүсгэж хяналт тавьж ажилласан.
- Байгууллагын хэмжээнд халдвар хамгааллын хэрэгслийн нөөцийг бүрдүүлэв

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах чиглэлээр:

Газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/33 дугаар тушаалаар Байгууллагын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, албан хаагчдыг мэдээллээр хангах дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл”-ийг байгуулж хариуцсан мэргэжилтэн томилон ажиллуулж байна. Зөвлөлийн эхний хурлаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам” боловсруулан батлуулсан. Томилогдсон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын ажилтан нь барилгын талбайд хяналт шалгалтаар ажиллах 14 албан хаагчдад 05 дугаар сарын 28-ны өдөр сургалт зохион байгуулж зөвлөгөө, мэдээлэл өгч албан хаагчдыг эрүүл мэндийг урьдчилан сэргийлж ажилласан. Сургалтад хамрагдсан албан хаагчдын бүртгэлийг хөтлөн баталгаажуулсан байна.



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газрын албан хаагчид ХАБЭА-н сургалтад хамрагдсан бүртгэл

Улаанбаатар хот 2020.05.18

А/А	Нэрс	Албан тушаал	Гарын үсэг
Удирдлага			
1	С.Тамирцүлэм	Газрын дарга	
2	О.Одъяргал	Орлогч дарга	
Захирааны хэлтэс			
3	Э.Даваажатан	Халтсийн дарга	
4	С.Болдоо	Хяналт, шалчилгаа, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	
5	Д.Мянмарсоймо	Тогтоол, шийдвэр, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	
6	П.Отгонцэцэг	Шуурхай асуудал хариуцсан мэргэжилтэн	
7	Ч.Энхтайван	Бичиг хэргийн ажилтан	Зөвлөлийн амралттай
8	Г.Оюунцэцэг	Архивын ажилтан	
9	н.Өнөрбилэг	Гадны харилцаа, хяналтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	
Боловсрол төлөвлөлтийн хэлтэс			
10	Б.Од-Эрдэнэ	Халтсийн дарга	
11	Б.Батцэцэг	Чанарын дад бүтцийн Ахлах мэргэжилтэн	
12	У.Санчир	Орчны стандартын мэргэжилтэн	Томилгоогоор өргөсөн
13	Б.Ариунзаяа	Харгалгачийн үйлчилгээний стандартын мэргэжилтэн	
14	Ц.Орхонбаяр	Тээврийн стандартын мэргэжилтэн	
15	Б.Биндэршяа	Хот төлөвлөлтийн стандартын мэргэжилтэн	
Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтэс			
16	Б.Ариунтуваа	Халтсийн дарга	
17	М.Цогтболзол	Хот байгуулалтын стандарт нэвтрүүлэлтийн мэргэжилтэн	
18	П.Мянсаага	Газрын стандарт нэвтрүүлэлтийн мэргэжилтэн	
19	Б.Холгорцэцэг	Орчны стандарт нэвтрүүлэлтийн мэргэжилтэн	
20	Э.Гаралт-Од	Орчны стандарт нэвтрүүлэлтийн мэргэжилтэн	
Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс			
21	Н.Билэгсайхан	Халтсийн дарга	
22	Д.Өлзийсайхан	Ахлах мэргэжилтэн	
23	Г.Амартувшан	Хуульч буюу орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	
24	М.Чингун	Менеджийн дад бүтэц хариуцсан мэргэжилтэн	Зөвлөлийн амралттай
25	Б.Ундармаа	Хот төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	
26	Г.Бат-Эрдэнэ	Материалын чанар хариуцсан мэргэжилтэн	
27	Б.Хулан	Газар ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн	

Зураг 5.3. ХАБ сургалт

Архивын сургалт, зөвлөгөө мэдээлэл.

“Архивын сан хөмрөг, нөхөн бүрдүүлэлт хийх, баримтыг эмхлэн цэгцлэх, үдэж хавтаслах” сэдвийн хүрээнд Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандартын дагуу баримт бичиг үйлдэх, баримт бичиг зохиож бүрдүүлэх,

найруулга зүй, хурлын тэмдэглэл хөтлөх ажлын арга зүйн сургалтыг зохион байгуулж газрын нийт албан хаагчдыг хамруулан ажиллав.



Зураг 5.4. 2020.06.26-ны өдөр “Архивын баримтыг нөхөн бүрдүүлэх” сэдвээр Захиргааны хэлтсийн Архивын ажилтан мэдээллийн цаг арга хэмжээг зохион байгуулав.

Байгууллагын эцэг эхийг зөвлөлийн үйл ажиллагаа, төлөвлөгөөний хэрэгжилт:

2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Байгууллагын ажилтан, албан хаагчдын хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, зөв иргэн болж төлөвших, нийгэмших, хүмүүжүүлэхэд нь эцэг эх, хүүхдийн хүмүүжил, боловсролыг дэмжигч байгууллагуудтай хамтран ажиллах зорилготой Эцэг эхийн зөвлөлийг байгуулсан. Тус зөвлөлийн гишүүн П.Отгонцэрэн зөвлөлийн 2020 оны хийх ажлын жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Төлөвлөгөөний дагуу 1 дүгээр улирлын төлөвлөгөөнд тусгагдсан ажил болох хүүхдийн баяраар уламжлал болгон зохион байгуулах анхдугаар “Гар зургийн уралдаан”-ыг зохион байгуулж шалгарсан 3-н байрт хүүхдүүдийн гарын бэлэг, газрын нийт албан хаагчдын 39 хүүхдийн бэлгийг судалгаа хийн сонгож, худалдан авсан ба холбогдох санхүүгийн баримтыг байгууллагын нягтлан, няравт хүлээлгэн өгсөн.



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн санаачилсан “Өгөөмөр нийслэлчүүд” арга хэмжээний хүрээнд:

Монгол Улсын хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн засварлах, устгах журмыг хэрэгжүүлэх, эх үүсвэр дээр хог хаягдлыг ангилан ялгах, багасгах, бууруулах, дахин ашиглах чиглэлээр иргэдийн мэдлэг оролцоог нэмэгдүүлэх зорилготой Өгөөмөр нийслэлчүүд арга хэмжээнд 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдөр тус газрын албан хаагчдаас цугларсан хүүхдийн тоглоом, хуучин хувцас, цүнх, цахилгаан хэрэгсэл зэргийг дээрх аяныг хариуцсан мэргэжилтэнд 95250669 дугаарын утсаар холбогдон Хангарди ордны

үүдэнд хүлээлгэн өгсөн ба зарим албан хаагчид оршин суугаа дүүргийн хороон дээр хуучин хувцас, хэрэглэлээ тус тус өгч идэвхтэй оролцсон байна.



Мэдээллийн цаг

Газрын албан хаагчдыг цаг үеийн шаардлагатай, танин мэдэхүйн ач холбогдолтой мэдээ, мэдээллээр хангах хүрээнд 14 хоног тутамд “Мэдээллийн цаг” арга хэмжээг зохион байгуулах хуваарийг гарган газрын даргаар батлуулсан.

2020 оны хагас жилийн байдлаар 9 удаа “Мэдээллийн цаг” арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: Захиргааны хэлтэс– 3, Стандарт хэрэгжүүлэлтийн хэлтэс-1, Орчны аюулгүй байдлын хяналтын хэлтэс-3, Бодлого төлөвлөлтийн хэлтэс-1, Мэдээлэл технологийн хэлтэс-1 мэдээллийн цагийг зохион байгуулсан байна.

Бусад

2020.06.19-ний өдрийн Газрын даргын “Эд хөрөнгийн тооллого явуулах тухай” А/50 дугаар тушаал батлуулж газрын хэмжээнд ашиглагдаж буй үндсэн хөрөнгө, бараа материалын 2020 оны хагас жилийн тооллогын ажлыг зохион байгуулав. Тушаалын дагуу газрын нийт албан хаагчдын эд хариуцагчийн картыг шинэчлэн, байгууллагын эд хөрөнгө, бараа материалын нэгдсэн программд шинэчлэлт хийж албан хаагч тус бүрийг эд хариуцагчийн тооллогын бүртгэлд бүртгэж гарын үсэг зуруулан баталгаажуулав.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Төсвийн задаргаа батлах тухай” А/199 дугаар захирамжийн дагуу газрын албан хэрэгцээнд худалдан авсан үйлчилгээний зориулалттай Хьюндай старикс Н-1 болон Соната ДН-8 загварын автомашинуудыг хүлээн авч, байгууллагын өмчид бүртгүүлж ажилласан.

Албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа бичиг хэргийн материалыг шаардах хуудсаар хэлтсүүдэд олгож, шаардах хуудсыг нярав /Бат-Эрдэнэ/-т цаг тухай бүр хүлээлгэн өгөв.



Шатахуун зарцуулалтыг хэмнэх зорилгоор тус газрын 0712 УНА улсын дугаартай автомашин ашиглалт, явсан км-ийн хуудас бөглүүлэн ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

Хагас жилийн байдлаар газрын дүрмээр хүлээх үүргээ хариуцлагаа хэвийн гүйцэтгэж ирлээ. Хотын стандартын баримт бичиг боловсруулах, Орчны аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр барилгын орчны аюулгүй байдлыг хангуулах, хашааг стандартад нийцүүлэн шинэчлэх, зорилтот жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, ННЗБ-ын албан хаагчдад сургалт зохион байгуулах гэх мэт томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтэд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, хурал зөвлөгөөний илтгэл материал бэлтгэх, Нийслэлийн Онцгой комиссоос сайжруулсан түлшний хэрэглээ, борлуулалт, Шинэ коронавирусийн халдвараас сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагаа зэрэг байгууллагын үндсэн чиг үүргийн болон цаг үеийн ажлуудыг цаг тухай нь гүйцэтгэн тайлагнаж газрын албан хаагчид мэдлэг чадвараа дайчлан ажилласан.

ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛ

“Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын баримт бичиг” нь Монгол улсын үндэсний стандарт, барилгын норм ба дүрэм дээр тулгуурлан боловсруулагдаж байгаа боловч Үндэсний стандартын иж бүрэн биш, уншихад ойлгомжгүй, муу орчуулагдсан, нэг зүйлийн талаар стандарт шаардлага нөгөө стандартын баримт бичигтэйгээ хол зөрүүтэй байдаг, хуучирч цаг үеийн шаардлага хангахгүй болсон, өдөр тутмын амьдралд тулгардаг хот төлөвлөлт, хот байгуулалтын олон асуудлын талаар зохицуулалт огт байхгүй байгаа зэргээс шалтгаалан шинэ зүйлсийг стандартчилсан шинжтэй боловсруулагдаж байна.

Стандартчилал, техникийн зохицуулалтын эрх зүйн үндэс, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд уг хуулиар хотын стандарт тогтоох эрхийг хуулиар тусгайлан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргад олгоогүй, хотын стандарт гэсэн стандартчиллын баримт бичиг байх, талаар тусгаагүй байна. Иймд эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Хотын стандартын баримт бичгийн тогтолцоог бий болгосноор иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг хангасан барилга, зам дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг олон улсын чанар стандартад нийцсэн байдлаар барьж байгуулах, бүх төрлийн хөрөнгө оруулалтын ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулж үр ашгийг дээшлүүлэх боломж нээгдэж байна.

Үүний тулд дараах арга хэмжээг авах шаардлага тулгарч байна. Үүнд:

1. Байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, судалгаа хөгжүүлэлт хийх үр чадвартай, төлөвшсөн, туршлагатай мэргэжилтэн албан хаагчдыг ажилд шалгаруулж авах;

2. Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалгаа хийж, олон улсын жишиг дэлхийн хотуудын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Хотын стандартын баримт бичгийг боловсруулах;
3. Хотын стандартын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаанд хотын амьдралд оролцогч бүх талуудын оролцоо санал зөвлөмжийг тусгах;
4. Үндэсний үйлдвэрлэл, дотоодын нөөцийг илүүтэй ашиглах нөхцөл бололцоог хангах;
5. Гадаад дотоодын судалгаа шинжилгээний байгууллага дэлхийн өндөр хөгжилтэй хотуудын хөгжлийн туршлага стандарт хэрэгжүүлэх чадвараас суралцах;
6. Хотын стандартын баримт бичгийг олон нийтэд таниулах сурталчлах, хэрэгжүүлснээр гарах үр ашгийг мэдрүүлэх;
7. Хотын стандарт баримт бичгийн хэрэгжилт хангагдах менежмент зохион байгуулалтын нөхцөлийг нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, мэргэжилтнүүдийн өдөр тутмын ажил үүрэгтэй нягт холбох;
8. Улаанбаатар хотын иргэдийн орчны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй аливаа асуудлыг судлан шийдвэрлэхэд хамаарал бүхий байгууллагуудын харилцан уялдааг сайжруулах, тухайн асуудлыг шийдвэрлэх байнгын зөвлөл, түүний ажиллах дүрмийг Нийслэлийн Засаг даргаар батлуулах, хэрэгжүүлэх